

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-4

1.Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингөөс Монгол Улсын Шадар сайдад хандаж тавьсан “Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын талаар” тавьсан асуулгын хариуг сонсох 5-27

2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/ 27-32

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 17 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Ж.Батжаргал, Г.Ганболд, О.Цогтгэрэл, Ж.Эрдэнэбат;
Чөлөөтэй: Г.Амартүвшин, А.Адъяасүрэн, Ц.Анандбазар, Ц.Туваан.*

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Байнгын хорооны дарга Т.Энхтүвшин “Эрдэнэс Тавантолгой Хувьцаат Компанийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгой орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт”-ийн талаарх Үндэсний аудитын газрын гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэхийг хойшлуулсныг мэдэгдэв.

Нэг.Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингөөс Монгол Улсын Шадар сайдад хандаж тавьсан “Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын талаар” тавьсан асуулгын хариуг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Цэндсүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай, мөн яамны Газрын тосны ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн П.Хүрэлхүү, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, мөн төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг, Санхүү, эдийн засгийн газрын дарга Б.Чинтуяа, Газрын тосны хайгуул, ашиглалтын газрын дарга Д.Буян-Арвижих, Төлөвлөлтийн инженерийн албаны дарга А.Баяржаргал, Дамжуулах хоолой хариуцсан албаны дарга Г.Болорчулуун, Технологийн албаны дарга Б.Мөнх-Эрдэнэ, Захиргааны ахлах мэргэжилтэн О.Энхбаяр, Төслийн зохицуулагч П.Анударь, Хэвлэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Т.Үүрцайх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн хэлтсийн референт Ж.Монголжингоо нар байлцав.

Асуулгын хариуг Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Цэндсүрэн танилцуулав.

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Г.Дамдинням, Д.Батлут, С.Ганбаатар, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, мөн компанийн Газрын тосны хайгуул, ашиглалтын газрын дарга Д.Буян-Арвижих, Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Цэндсүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир үг хэлэв.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингөөс Монгол Улсын Шадар сайдад хандаж тавьсан “Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын талаар” тавьсан асуулгын хариуг сонслоо.

Уг асуудлыг 11 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Цэндсүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай, мөн яамны Газрын тосны ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн П.Хүрэлхүү, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, мөн төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг, Санхүү, эдийн засгийн газрын дарга Б.Чинтуяа, Газрын тосны хайгуул, ашиглалтын газрын дарга Д.Буян-Арвижих, Төлөвлөлтийн инженерийн албаны дарга А.Баяржаргал, Дамжуулах хоолой хариуцсан албаны дарга Г.Болорчулуун, Технологийн албаны дарга Б.Мөнх-Эрдэнэ, Захиргааны ахлах мэргэжилтэн О.Энхбаяр, Төслийн зохицуулагч П.Анударь, Хэвлэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Т.Үүрцайх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн хэлтсийн референт Ж.Монголжингоо нар байлцав.

Байнгын хорооны дарга Т.Энхтүвшин тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Т.Энхтүвшин: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төсөлд дор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилд зориулан буцаж гарах нөхцөлтэйгөөр импортоор оруулах техник, тоног төхөөрөмжийн гаалийн нутаг дэвсгэрт түр горимд байх хугацааг тухайн үйлдвэр барьж дуусах хугацаагаар зохицуулах асуудлыг шийдвэрлэх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Т.Энхтүвшин: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Төсөлд дор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“Шинжлэх ухаан, технологийн их сургуульд газрын тосны инженерчлэлийн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын сургалтын төлбөр, дадлагын зардлыг шийдвэрлэх талаар холбогдох төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай арга хэмжээ авах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Т.Энхтүвшин: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, С.Ганбаатар нарын гаргасан, Төсөлд дор дурдсан 3 дугаар зүйл нэмэх:

“газрын тосны олборлолтыг орд ашиглах үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнд заасан хэмжээнд хүргэх зорилгоор хайгуулын ажлыг нэмэгдүүлэх, олборлосон тосыг Монгол Улсад баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэхтэй холбогдуулан “Петрочайна Дачин Тамсаг” компани болон түүний дээд байгууллага болох Хятадын газрын тосны үндэсний корпорац, Дачин Ойлфийлд компанитай хэлцэл хийх, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу ирээдүйд олборлох газрын тосыг Монголын газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэхийг баталгаажуулах, хамтарсан хайгуул хийх талаар судалж, ажлыг эрчимжүүлэх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Т.Энхтүвшин: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Н.Наранбаатар нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 9 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 12 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 51 минут үргэлжилж, 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Т.ЭНХТҮВШИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 17 минут.

ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Т.Энхтүвшин: Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя та бүхэндээ.

2 дугаар тойрог Баян-Өлгий Тилеуханы Аубакир, 20 дугаар тойрог, Орхон Дамбын Батлут гишүүн, 4 дүгээр тойрог, Булган Жадамбын Бат-Эрдэнэ, 20 дугаар тойрог, Орхон Сайнхүүгийн Ганбаатар, 19 дүгээр тойрог, Дархан Гонгорын Дамдинням, 11 дүгээр тойрог, Өмнөговь Нанзадын Наранбаатар, 8 дугаар тойрог, Дорноговь Төмөртогоогийн Энхтүвшин.

Ирц 52, хэн гарччав? 1 карт хөөе. 1 дүгээр тойрог Архангайн Ганзоригийн Тэмүүлэн гишүүн гээд нийт ирц 52.9 хувь хүрсэн учир хуралдаанаа эхлүүлж байна.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Нэг дэх асуудал. Үндэсний аудитын газраас “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн 2018 оноос 2020 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцүүлэхээр энэ долоо хоногийн тов дараалалд тусгагдсан байсан боловч дээрх дүгнэлттэй гишүүд танилцаж амжаагүй тул уг дүгнэлтийн талаар Үндэсний аудитын газраас нэмж

тодруулга авах шаардлага байгаа тул өнөөдрийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг бас хойшлуулж байна.

Хоёр дахь асуудал бол Улсын Их Хурлын гишүүн Үйлдвэржилтийн байнгын хорооноос Монгол Улсын Шадар сайдад хандаж газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын талаар тавьсан асуултын хариултыг бас сонсоно.

Хэлэлцэх асуудалтай саналтай гишүүд байна уу. Алга байж байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Шадар сайдад хандан газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын талаарх тавьсан асуултыг сонсоно.

Ажлын хэсгийн гишүүд ээ оруулаарай. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхтэй холбогдуулан хуралдаанаас дараах асуудлыг гаргаж байна.

Монгол Улсын Их Хурлын хуулийн 8.1.13-д заасан гишүүний бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Шадар сайдад хандан газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын талаар асуулт тавьсан байж байгаа. Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн III дүгээр зүйлд заасны дагуу Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг Байнгын хороонд гаргасан. Мөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12.4-д заасны дагуу Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар Засгийн газар чиглэл болгосон Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулж, өнөөдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр Байнгын хорооны хуралдаанд уламжилсан. Энэ асуудлыг өнөөдрийн хуралдаанаар мөн хэлэлцэнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг та бүхэнд танилцуулъя.

Цэндсүрэн Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн дэд сайд. Дэд сайд босоорой. Хишигдалай Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яамны Газрын тосны бодлогын газрын хэлтсийн дарга. Хишигдалай байна уу. Хүрэлхүү Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яамны Газрын тосны ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр төрийн өмчит компанийн захирал Алтанцэцэг, Чинзориг Гэрээ эрх зүйн газрын дарга, Чинтуяа Санхүү эдийн засгийн газрын дарга, Буян-Арвижих Газрын тосны хайгуулын ашиглалтын газрын дарга, Баяржаргал Төлөвлөлтийн инженерийн албаны дарга, Болорчулуун Дамжуулах хоолой хариуцсан албаны дарга, Мөнх-Эрдэнэ Технологийн албаны дарга, Энхбаяр Захиргааны ахлах мэргэжилтэн, Анударь Төслийн зохицуулагч, Үүрцайх Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна.

Мэдээллээ сонсох уу. Мэдээллийг чинь хэн сонсох билээ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад гишүүний асуулт байхгүй. Мэдээллийг Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яамны дэд сайд Цэндсүрэн танилцуулах юм байна шүү. Дэд сайд танилцуулгаа хийе. 2 номерын микрофон өгөөрэй.

О.Цэндсүрэн: Та бүхэнд өнөөдрийн амар амгаланг айлтгая. Монгол Улсын Засгийн газарт Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас олгохоор шийдвэрлэсэн 1.2 сая ам. долларын хөнгөлөлттэй зээлийн 1 тэрбум 236 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг Дорноговь аймгийн Алтаниширээ сумын нутагт 2017 оноос хэрэгжүүлж байна.

Энэхүү үйлдвэр байгуулагдсанаар жилд 43 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий, 339 мянган тонн АИ-95 авто бензин, 40 мянган тонн онгоцны түлш, 864 мянган дизелийн түлш, нийт 1.3 сая мянган тонн стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хий энэ нь манай дотоодын нийт бүтээгдэхүүний 55 хувийг хангах боломжтой гэсэн тооцоотой байгаа.

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл нь 4 багц асуудлаас бүрдэж байгаа. Эдгээрт ЕРС-1 энэ технологийн бус барилга, ЕРС-2 буюу анхдагч технологийн байгууламж, ЕРС-3 үйлдвэрийн цахилгаан станц, ЕРС-4 буюу лицензтэй байгууламжийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлууд багтаж байгаа юм. Эдгээрээс ЕРС-ийн багцын барилгын угсралтын ажил 2023 оны 3 сард эхлүүлсэн бөгөөд төслийн талбайд 647 инженер, техникийн ажилчид ажиллаж байна.

Иргэний байгууллагуудын дотор агаарын сэргэлтийн хоолойн угсралт, дотор ханын өрлөг, каркас угсралт, гадна болон дотор барилгын ажил, цахилгааны ажлууд, заслын ажлууд ингээд нийт ажлын барилга угсралтын багц ажил 83 хувьтай явагдаж байна. ЕРС-2 болон ЕРС-3 багцын ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан “Megha Engineering Infrastructure Limited” компани төслийн менежментийн зөвлөх, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн инженерүүдийн оролцоотойгоор архитектурын даалгаврыг Барилга, хот байгуулалтын яам, ерөнхий төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Онцгой байдлын газар зэрэг байгууллагуудаар батлуулаад ажиллаж байна.

Одоо ЕРС-4 багцын ажлын ерөнхий гүйцэтгэлийг сонгон шалгаруулах тендерийн үнийн саналыг

2023 оны 3 сарын 29-нд нээж, техникийн болон санхүүгийн үнэлгээ хийж дуусгасан. Тус тендерт техникийн шаардлага болон үнийн хамгийн бага саналаар Megha Engineering Infrastructure Limited компанийг шалгаруулаад байгаа. Компанитай тендерт ирүүлсэн үнийн саналыг боловсруулах хэлэлцээр болон бууруулах болон гэрээний төсөл дээр ажиллаж байна. EPC-4 багцын гидрокрекинг, дизелийн гидро цэвэрлэгээ, бензин үйлдвэрлэх байгууламж зэрэг төсөлд лиценз эзэмшигч “UOP” компаниас ирүүлсэн зарим өөрчлөлтүүдийг хянах шатандаа ажиллаж байна. Хянаж ажиллаж байна. Монгол Улсын Хөгжлийн банкнаас төсөл хэрэгжүүлэх компанийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх зорилгоор тус компанийн талаар авах арга хэмжээний тухай тогтоолын төслийг Засгийн газрын 2023 оны 3 сарын 1-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Монгол газрын тос боловсруулах үйлдвэр төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах арга хэмжээний тухай 62 дугаар тогтоолыг батлуулсан, 82 дугаар тогтоолыг батлуулсан.

Дамжуулах хоолойн талаар Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 сарын 2-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажлыг 2025 оны эхний улиралд багтаан дуусгахаар төлөвлөсөн.

Өнөөгийн байдлаар байр зүйн зураглалын судалгааны ажил 100 хувь хийгдсэн байгаа. Мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил 100 хувь, геотехникийн судалгааны ажил 95 хувьтай байна. Техникийн зураг төслийн ажил 90 хувьтай, худалдан авалт явагдаж байна. 6.8 хувьтай явагдаж байна. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажил хийлгэсэн. Түр кемпүүдийн барилга угсралтын ажил 48 хувьтай байна. Түр замын ажил 28 хувьтай, төслийн ерөнхий гүйцэтгэл инженерчлэл 51 хувьтай, барилга угсралт 7 хувь гүйцэтгэлтэй байна.

Дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх гэрээнд заасан хэмжээнд хүрэхгүй тохиолдолд ажил тасалдах, цаг алдахаас гадна гэрээнд заасны дагуу их хэмжээний нөхөн төлбөр төлөх төлбөр манай талаас шаардах эрсдэлтэй байна.

Ингээд Ерөнхий боловсруулах үйлдвэр.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Дэд сайд наад мэдээллээ гүйцэд өгчих. Энэ чинь нэлээн олон хуудас юм байна шүү дээ. Монгол Улсын Шадар сайдаас энэ асуултын хариулттай холбогдуулаад ингээд мэдээлэл өгчихсөн. Энэ мэдээллийг та гүйцэд унших л даа. Тийм, наадхаа нэмж мэдээллээ өгөөд яв. Энэ мэдээлэл өгсөн байгаа биз дээ. Энэ Шадар сайдаас ирсэн мэдээлэл. 2 номерын микрофон өгөөрэй.

О.Цэндсүрэн: Энхтүвшин дарга энэ мэдээллийг Амарбаясгалан дарга хийнэ, бид нарыг асуулт, хариултад бэлдэж ирээрэй гэсэн ийм чиглэл өгсөн өнөөдөр 9 цагийн алдад. Тийм болохоор ерөнхий мэдээлэл байхгүй байна.

Т.Энхтүвшин: Үгүй ээ, өчигдөр юу гэдэг юм Амарсайхан Шадар сайдаас энэ Үйлдвэржилтийн байнгын хороонд гээд албан тоот ирүүлсэн шүү дээ. “Монгол газрын тос” төрийн өмчит үйлдвэрийн газрын асуудлыг “Эрдэнэс Монгол” Наранцогтод, мэргэжлийн өндөр зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам, Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаарх тухай асуудлыг хариуцсан чиг үүрэг бүхий албан тушаалтнаас танилцуулах мэдээллийг авах нь зүйтэй гээд ингээд мэдээлэл ирчихсэн. Энэ зөвхөн Шадар сайдаас ирсэн мэдээллийг л та уншаад танилцуулчих л даа. Энэ Үйлдвэржилтийн байнгын хорооноос Шадар сайдад энэ Монгол газрын

тостой холбоотой асуулга тавьсан байж байгаа

Тэгээд энэ мэдээллийг л та бичгээр ирчихсэн юмыг л уншаадах л даа. Хариулах хүмүүс нь тэртээ тэргүй Газрын тос төрийн өмчит компанийн хүмүүс байж байна.

О.Цэндсүрэн: Үргэлжлүүлээд танилцуулчихъя. Төслийн нийт хөрөнгө оруулалтын зардал болон энэ төслүүдийн багцын талаар танилцуулчихсан.

Төслийн нийт хөрөнгө оруулалтын зардал болон зээлийн дүнг нэмэгдүүлэх талаар.

Өнөөгийн байдлаар газрын тос боловсруулах үйлдвэрийн 4 багц ажлаас 3 багц ажлын гэрээг байгуулж, Энэтхэгийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн шугамд оруулаад байна. Үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан ажил, төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ, лиценз эзэмшигчтэй байгуулсан гэрээнүүдийн хүрээнд хийгдэх ажлыг тус зээлээс санхүүжүүлж байгаа бөгөөд гэрээний нийт үнийн дүн 1 тэрбум 10 сая ам.долларын болоод байна.

ЕРС-4 багцын ажлын гэрээг 648 сая ам.доллаар байгуулахад төслийн нийт хөрөнгө оруулалтын зардал 1 тэрбум 658.9 сая ам.доллар болох буюу болох буюу 2018 онд байгуулсан техник, эдийн засгийн үндэслэлээр тооцоолсон зардал, хөнгөлөлттэй зээлийн дүнгээс 30 орчим хувиар өсөхөөр байна.

Газрын тос боловсруулах төслийн менежментийн зөвлөхөөр ажиллаж буй Энэтхэгийн Engineers India Limited компани нь дэлхийн зах зээл дээр сүүлийн жилүүдэд үүссэн эдийн засгийн хямрал, бүх төрлийн бараа материал, техник тоног төхөөрөмжийн үнийн өсөлтийг дахин тооцож, үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зардлыг 2023 оны байдлаар

шинэчлэн ирүүлсэн нь мөн 35 хувь орчим өссөн дүнтэй гарсан байна.

Энэтхэгийн тал Засгийн газрын хамтран хэрэгжүүлж байгаа стратегийн төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгахад онцгойлон анхаарч нэмэлт зээлийн шугам нээх зайлшгүй шаардлага бий болж байгаа талаар төсөлд оролцогч талуудын ээлжит хурлын үеэр хөндөж ярилцаад байна.

Харин манай талаас зээлийн шугамыг нэмэгдүүлэх хүсэлтээ Энэтхэгийн талд албан ёсоор гаргаж, ингэхдээ үйлдвэр ашиглалтад оруулахад эхний ээлжид гарах үйл ажиллагааны болон магадалиггүй ажлын зардлыг тооцож оруулах нь зүйтэй гэсэн зөвлөгөө өгөөд байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийг өөрчилсөнтэй холбоотойгоор үүсэж буй хүндрэлүүд, Хөгжлийн банкны санхүүжилт зогссонтой холбоотойгоор газрын тосны боловсруулах үйлдвэр байгуулах төсөл хэрэгжүүлэгч компанийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх зорилгоор Засгийн газрын 2023 оны 3 сарын 1-ний өдрийн 82 дугаар тогтоол гарсан боловч тогтоолын зарим заалтууд тодорхой бус шат дамжлага нэмсэн, гадаадын хөнгөлөлттэй зээлтэй холбоотой Сангийн яамны дагаж мөрдөх журам, дүрэмд нийцээгүйгээс үйлдвэрийн бүтээн байгуулалтын санхүүжилт, татвараас чөлөөлөх, хил гаалиар нэвтрүүлэх асуудлууд 2 дугаар сараас хойш саатаж, цаг хугацааны ихээхэн хохирол бий болж гэрээлэгч байгууллагуудаас нөхөн төлбөрийн асуудал яригдаж эхлээд байна.

Энэтхэгийн Гадаад хэргийн яам, Экспорт-Импорт банкны зүгээс уг асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлага тавиад байна. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн зарцуулалт эхэлсэн 2018 оноос хойш төслийн

санхүүжилт, хөтөлбөрийн асуудал газрын тос боловсруулах үйлдвэрээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн ямаар уламжлан Сангийн яаманд хүргүүлж, Сангийн яамнаас Бүгд Найрамдах Энэтхэг улсын Элчин сайдын ямаар дамжин Энэтхэгийн Экспорт-Импорт банканд хүргэгддэг байсан. Тогтоол гарснаас хойш төсөл хэрэгжүүлэгч компани Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, “Эрдэнэс Монгол” компаниуд хоорондоо албан бичиг солилцож, энэ хооронд гэрээлэгч компаниудын санхүүжилт олгогдохгүй урт хугацаагаар саатан хилийн гадна талд их хэмжээний тоног төхөөрөмж, бараа материалууд гацаж, зарим хэсэг нь Энэтхэгийн боомтоос ачигдаж чадахгүй хүлээгдэж байна.

Мөн тогтоолд газрын тосны боловсруулах үйлдвэрийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэх талаар тодорхой тусгагдаагүй. Иймээс “Эрдэнэс Монгол” компанийн зүгээс санхүүжилтийг зөвхөн богино хугацааны эхний 2 улирал хүүтэй зээл олгох замаар шийдвэрлэх боломжтой гэж мэдэгдсэн бөгөөд ажиллагсдын цалинг тавихын тулд жилийн 10.9 хувийн хүүтэй зээлийн гэрээг 2023 оны 4 сарын 6-ны өдөр байгуулсан болно.

Засгийн газраас гаргах шийдвэр нь компанийн санхүүгийн хүндрэлийг арилгах зорилготой байсан боловч дахин Хөгжлийн банкттай ойролцоо хүүтэй зээл авахад хүргээд байна. Газрын тосны боловсруулах үйлдвэр төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг шилжүүлэгчээр “Эрдэнэс Монгол” компанийг тогтоож ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих үүрэг өгөгдсөн нь зарим талаар чиг үүргийн давхцалыг бий болгож байна. Тухайлбал, Үйлдвэрийн төслийн зураг төслөөс инженерчлэл, барилга угсралт хүртэлх бүхий л үе шатын ажлын явц, гүйцэтгэлд төслийн менежментийн

зөвлөх Бүгд Найрамдах Энэтхэг Улсын “Engineers India” компани, төсөл хэрэгжүүлэгч компанитай хамтран хяналт тавьж ажилладаг. Мөн зээлийн хөрөнгийн зарцуулалт Сангийн яам Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Гадаад хэргийн яам, Экспорт-Импортын банк байнгын хяналт тавьж, бүхий л оролцогч талуудаас тайлан мэдээ авч хэлэлцэж, асуудлыг шийдвэрлэн ажилладаг.

Үйлдвэрийн хотхонтой холбоотой асуудал.

Бид ажлыг үргэлжлүүлэхийн тулд өөрсдийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэх боломжтой бүхий л арга хэмжээг авсны эцэст барилгын ажлын зураг төсөв, тоо хэмжээний зөрүүд 2.1 тэрбум төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх барилга байгууламжийн төсөвт өртгийн өөрчлөлтийг тооцох түр журмын дагуу материалын үнийн өсөлтөд 6.6 тэрбум төгрөг, нийт 8.7 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийг олгох боломжтой талаар Барилга, хот байгуулалтын яаманд мэдэгдэж үнэ өсгөсөн дүнгээр ажлаа үргэлжлүүлэх санал тавьсан боловч хүлээж аваагүй, Газрын тос боловсруулах үйлдвэрийн зүгээс хууль тогтоомжоос давсан шийдвэр гаргаж үнийн дүнг их хэмжээгээр өсгөх эрхгүй юм.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба төслийн ажилтай танилцаж тулгамдсан асуудлуудаар мэдээлэл авсан бөгөөд Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн туслан гүйцэтгэгч нар ажлаа үргэлжлүүлэхгүй тохиолдолд тус ангиар хотхоны 2 дугаар ээлжийн барилгын ажлыг хийлгэж дуусгах асуудлыг судлахаар болсон.

Сүүлийн жилүүдэд туслан гүйцэтгэгч нарын 1 нь манай талаас нэмэгдүүлэх боломжтой санхүүжилтийн дүнг хүлээн зөвшөөрч ажлаа үргэлжлүүлэх хүсэлтэй байгааг илэрхийлж байгаа бөгөөд энэ асуудлаар

бид Батлан хамгаалахын сайдад хандаж уг компанийн ажлыг яаралтай үргэлжлүүлэх, үлдэгдэл ажлыг хэрхэн гүйцэтгүүлж дуусгах талаар тодорхой шийдэл гаргаж өгөхийг хүсэлт тавиад байна.

Хотхоны барилга угсралтын ажлыг түргэн шуурхай дуусгаж, зориулалтын дагуу ашиглахын тулд төр засгийн дэмжлэг шаардлагатай байна. Сайншианд хотын ерөнхий төлөвлөгөөнд хотхоны сургууль, цэцэрлэгтэй байхаар тооцсон бөгөөд барилгын ажлыг 3 дугаар хэсэг болгон үргэлжлүүлнэ. Үйлдвэрийн ирээдүйн ажиллагсдыг үе шаттайгаар хотхонд амьдруулах болсонтой холбоотойгоор тэдгээрийн хүүхдийг тохилог сургууль, цэцэрлэг, боловсрол олгох шаардлага тулгамдаж байна.

Сургууль, цэцэрлэг барих санхүүжилтийг улсын, орон нутгийн төсөвт суулгаж өгөхийг хүсэж байна.

Гаалийн түр горимын талаар.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилд зориулан олон тооны машин механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг Монгол Улсад импортоор оруулж ирж байгаа бөгөөд цаашид үйлдвэрийн ЕРС-2, 3, 4 дүгээр багц ажлууд болон түүхий тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын механик угсралтын ажлууд эхэлж байгаатай холбоотойгоор энэ тоо хэд дахин нэмэгдэх болно.

Томоохон хэмжээний бүтээн байгуулалтын ажил нь урт хугацаанд үргэлжлэх тул ерөнхий гүйцэтгэгчийн ажилд шаардлагатай дээрх машин механизм, тоног төхөөрөмжийг гаалийн түр горимд байршуулах, цаашид сунгах боломжгүйгээр 1 жилийн хугацаатай импортоор оруулж ирэх хугацаа дуусмагц анх импортолсон улс руу нь, Энэтхэг улс руу буцаан гаргаж дахин оруулж ирэх нөхцөлийг Сангийн яамнаас

тавьж байгаа нь гүйцэтгэгчдийг хүндрэлтэй байдалд оруулж байна.

Барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгч Энэтхэг улсын компаниудын зүгээс гаалийн горимтой холбоотой тавигдаж буй шаардлагаас болж хөрөнгө санхүүгийн хохирол үүсэж, цаг хугацаа алдаж байгаа талаар Монголын талд удаа дараа мэдэгдэж түр горимын хугацааг төсөл хэрэгжих хугацаагаар сунгаж өгөх, эсхүл дээр дурдсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд татвараас чөлөөлж бүрмөсөн горимоор импортлох хүсэлтийг тавиад байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2 орны Засгийн газрын оролцоотойгоор байгуулж буй газрын тос боловсруулах үйлдвэрийг хугацаа алдахгүй барьж байгуулах нь нэн чухал бөгөөд Сангийн яамнаас энэ асуудлыг яаралтай шийдвэрлэх арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Түүхий тосны талаар.

Үйлдвэрийн түүхий эдийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Петрочайна Дачин Тамсаг” компанийн олборлолт явуулж буй газрын тосны Тосон уул-19, Тамсаг-21 дүгээр ордуудаас хангахаар төлөвлөсөн. Газрын тосны тухай хууль Монгол Улс Улсад газрын тос боловсруулах үйлдвэр барьсан тохиолдолд гэрээлэгчид ноогдох газрын тос болон өртөгт газрын тосыг тэргүүн ээлжид авах зээлийн үнээр худалдаж авах давуу эрхийг эдлэх, түүнчлэн Газрын тосны газар “Петрочайна Дачин Тамсаг” компанийн хооронд 2011 оны 6 сарын 24-ний өдөр байгуулсан протоколд “Петрочайна Дачин Тамсаг” компанийн бүтээгдэхүүн хаах гэрээний дагуу өөрт оногдох түүхий тосыг тэргүүн ээлжид Монгол Улсад нийлүүлнэ гэж тус тус заасан байдаг.

Үйлдвэр ашиглалтад орох хугацаа ойртож түүхий эдийн асуудал нэн тулгамдаж байгаа учир Засгийн газраас “Петрочайна Дачин Тамсаг” компани

болон түүний дээд шатын байгууллага болох Хятадын газрын тосны үйлдвэрийн корпорац “CNPC” корпорацтай яриа хэлэлцээ хийх, Монгол Улсын холбогдох хууль болон бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу ирээдүйд олборлох газрын тосыг Монгол газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, газрын тосны нөөцийг нэмэгдүүлж, олборлолтын хэмжээг орд ашиглалтын төлөвлөгөөнд заасан 1.5 сая тонн жилд хүргэх асуудлыг баталгаажуулах шаардлагатай байна.

Үйлдвэрийн түүхий эдийг бэлтгэхэд тодорхой хувь нэмэр оруулах зорилгоор Засгийн газраас газрын тос боловсруулах үйлдвэрт олгосон Давст-31 талбайн хайгуулын ажлын өгөгдөлд үнэлгээ, судалгааны ажлуудыг хийж байгаа боловч хяналтын ганц цооног өрөмдөгч санхүүгийн эх үүсвэр байхгүй байна.

Т.Энхтүвшин: Сайдаа зогсоё наадхаа. Тийм, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 11.1.2-т Байнгын хорооны хуралдаанд асуултын хариуг холбогдох албан тушаалтан 3 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асууна гэсэн ийм заалт байгаа учир 5 минут шахуу болчихлоо. Ер нь бол Монгол Улсын Шадар сайдад хэдхэн асуудал тавьсан байгаа шүү дээ.

Нэгдүгээрт EPC-1 дүгээр төсөл хэзээ дуусах вэ? 2 дугаар төслийн ажил ямар шатандаа явж байна? 3 дугаар төслийн ажил тендер нь зарлагдсан уу, зарлагдаагүй юу. Нефтийн хоолой дамжуулах хоолойн ажил нь хэр явцтай явж байна. Нефтийн боловсруулах үйлдвэрийг дагалдуулсан хотхоны ажил хэзээ дуусах вэ. Мөн газрын тос төрийн өмчит хязгаарлагдмал компанийн санхүүжилтийн асуудал. Хэдхэн л ийм асуудлууд байж байгаа. Тэгээд та хэд энэ дээрээ уул нь нэлээн анхааралтай хандаад нэлээн бараг 3, 4 сарын өмнө

тавьсан асуудал шүү дээ Монгол Улсын Шадар сайдад.

Тэгээд Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яамны хамгийн гол салбар энэ нефть боловсруулах үйлдвэрийн асуудал шүү. Ганц хайгуул биш, олборлолт биш энэ үйлдвэрийн асуудал бол Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яамны хамгийн гол асуудал гэж би бодож байгаа юм.

Мэдээлэлтэй холбогдуулаад асуулт асууя. Гишүүд нэрээ өгөөрэй. Ганбаатар гишүүнээр тасаллаа. Аубакир гишүүн асуултаа асууя.

Т.Аубакир: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ асуулт асуух ч гэж дээ бид нар энэ өгсөн мэдээллийг уншаад сууж байна л даа. Эрүүл ухаантай хүн бол аягүй хурдан ойлгогчихоор л асуудал. Монгол Улсын Засгийн газраас санаачлаад Монгол Улсад бас дотооддоо нефть үйлдвэрлэх боломжтой юм гээд 2 улсын Засгийн газар хоорондоо тохироод тухайн төслийн нэгж нь би бол төслийн нэгжийнхнийг мэдэж байна. Анх сонгогдож орж ирснээс хойш энэ Алтанцэцэг захиралтай хүмүүс ингээд л хөлөө хүрэх газраа л гүйж байгаа. Яг одоо энэ өгсөн мэдээллээс ингээд харахад энэ манай энэ засгийн түвшинд яамнуудын бүтэц энэ ажил хариуцсан хүмүүсийн хайнга, ер нь манай Монгол хүмүүс бид нар ч тийм хариуцлагагүй тийм заваан зантай л даа. Аягүй ойлгомжтой л саад тотгорууд байгаа. Энийг хариуцсан Засгийн газар нь байгаа, Хэрэг эрхлэх газар нь байж байна, Эрдэнэс Монгол нь байж байна. Сэтгэл гаргаад гүйх юм бол энэ болохгүй ажил биш л дээ. Одоо бид нар энэ дээр асуулт асуусан болоод л яамдын удирдлагууд сая тавьж байгаа танилцуулга энэ тэр та нар хариулсан болоод л өнгөрнө дэд сайдаа. Энэ бол бас л танай яамтай холбоотой л асуудал.

Ер нь энэ ажлыг бариад яг сэтгэл хийчихье гэсэн хүн хийчихдэг байхгүй юу. Би энэ Алтанцэцэг захирлыг мэдэж

байгаа юм. Сүүлд харин овоо тэвчээртэй. Эмэгтэйчүүд тэвчээртэй л байдаг л даа. Бүүр аргаа барж байгаа энэ үнэхээрийн. Энэ манай Байнгын хороонд холбоотой асуудал тийм ээ. Энэ чинь гааль дээр жишээлбэл 1 жилийн хугацаатай түр горимоор орж ирээд техник ашиглаад буцаана. Энэ чинь ямар ч тэнэг хүн ойлгомжтой шүү дээ. Энэ чинь урт хугацааны хөрөнгө оруулалтын ажил тэр техник тоног төхөөрөмж нь урт хугацаагаар оруулж ирэх боломжийг нь Засгийн газар Сангийн яаманд үүрэг өгөөд болоо. 1 жилийн хугацаанд орж ирсэн тэр экскаватор, трактор техник буцаад Энэтхэг рүүгээ гараад, дахиад бүрдүүлэлт хийгээд бүүр сүүлдээ ингээд асуухаас ч уур хүрмээр ч юм шиг нөгөө бөөсөнд гомдоод дээлээ шатаана гэгчээр бид нар тэнэгээ гайхаад ингээд дуугүй яваад байх бас хэцүү энэ зээлтэй холбоотой асуудал байж байгаа. Хуучин Хөгжлийн банкнаас санхүүжээд явдаг байсан. Эсвэл энэ Эрдэнэс Монголын удирдлагууд чинь хөөцөлддөггүй юм уу, эсвэл Монгол Улс нефтийн үйлдвэртэй болчихоосой гэж боддоггүй юм уу тэр хүмүүс чинь. Энэ чинь Засгийн газар дээр асуудлаа оруулаад л энэ зээл, санхүүжилтийн асуудлыг нь шийдээд л, гаалийг дуудаад л, Сангийн яамыг нь суулгаж байгаад л асуудлыг нь шийдчих л асуудал шүү дээ.

Сүүлдээ энэ ер нь сүүлийн үед ажиглагдаад байгаа юм. Энэ төрийн байгууллагууд төрийн албан хаагчдын энэ сэтгэлгүй байдал, ажилдаа ажлаа мэддэггүй арчаагүй байдал, сэтгэл гаргадаггүй, авлигал аваад л суухаа л боддог. Тэр улсын ажил байна уу, юу байна ерөөсөө хамаагүй. Хувийн ажлаа бол Зайсан толгой дээр мөнгө тавьчихсан бол хамгийн түрүүнд гүйж очоод л авна. Одоо сүүлд асуусан, асуулт асуух сонирхол ч алга. Аягүй ойлгомжтой асуудлууд байдаг. Засаг руугаа яагаад оруулдаггүй энийг хариуцсан ерөнхий албан тушаалтнууд нь. Энэ үйлдвэрийн ажлыг үйлдвэртэй больё гэж байгаа бол барих.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Санал байлаа. Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Ганц, хоёр асуулт байна. Энэ эдийн засгийн газраас олгож байгаа мөнгө маань яг гэрээндээ яг хэд гээж заасан бэ, нэг.

Хоёрдугаарт манай төсөл маань анх ямар үнэтэй байсан бэ, хоёр.

Гуравдугаарт яг ямар үнэтэй сүүлд техник, эдийн засгийн үндэслэл энэ тэрээ юмнуудаа хийгээд энэ ЕРС-4 гэрээний чинь хүрээнд нийт яг ямар өртөгтэй болчихоод байгаа вэ? Нөгөө Энэтхэгийн Засгийн газраас авч байгаа мөнгөндөө хүрч байгаа юу, эсвэл яг нэмэлт орж байгаа юу? Энэ тоонуудыг бүр тодорхой хэлээд өгөөч.

Хоёрдугаарт энэ Петрочайна компанитай гэрээ хийгдсэн байгаа гээд байгаа юм. Бүтээгдэхүүн хуваах гэрээ. Яг одоо бүтээгдэхүүн хуваах өөрсдийнхөө бид нар Монголд байгаа, Монголд ноогдож байгаа бүтээгдэхүүнээсээ гадна Хятадад Петрочайна компанийн Хятадын талд ноогдож байгаа хувийг бид нар бүтнээр нь 100 хувь авч энэ үйлдвэрлэлээ хийх үү?

Хоёрдугаарт яг энэ ямар үнээр нийлүүлэгдэх вэ? Олборлож байгаа үнээрээ юү, зах зээлийн үнээр юү?

Гуравдугаарт энэ хоолой дамжуулах тендер явагдаад байсан шүү дээ. Хоолой, дамжуулах хоолой энэ чинь яг ямар хоолой байхаар сүүлд тусгагдсан байна? Нөгөө халаадаг боолгоё энэ тэрээ гээд л замдаа эсвэл нэлээн татуурга шахуургатай байлгая, халаадаг боолгоё эсвэл халааж байгаад явуулья ч гэл үү янз янзын технологиуд яригдаад байсан шүү дээ. Хамгийн сүүлийн технологи нь яг юун дээр очсон бэ?

Дөрөвдүгээр асуулт болчих шиг боллоо энэ ЕРС-2 чинь орж ирээд явж

байх шиг байна. Яг үйлдвэрлэлийн чанартай юунууд чинь түрүүний тэр ярих шиг тендерт зарлагдаад яг үйлдвэрлэлийнх нь тэр дамжуулах хоолойтой, туслах үйлдвэрлэлтэй холбоотой барилга байгууламж гэж танилцуулаад байх шиг байна. Энэ маань яг хэзээ эхлэх юм бэ? Өөрөөр хэлбэл яг үйлдвэрлэлийн процессууд чинь, үйлдвэрлэлийн шинж чанартай барилгууд чинь хэзээ яг баригдаж эхлэх гээд байна? Та нарын төсөөллөөр ер нь бүтээн байгуулалтын 4 ажил чинь ер нь хэзээ дуусна гэсэн тооцоололтой байгаа вэ? 25 гэсэн 25-аар чинь аль нь орно гээд тэгж сая танилцуулчав? Ямар ч байсан нийт 4 процесс ЕРС-4-өө хийгдээд дуусахад ер нь цаг хугацааны хувьд хэдэн ямар он, хэдэн онд ашиглалтад өгнө гэсэн тооцоолол гарч байх шиг байна? Энэ хэдэн асуултад хариулж өгөөч.

Т.Энхтүвшин: Алтанцэцэг дарга 4 номерын микрофон өгөөрэй.

Д.Алтанцэцэг: Сайн байцаана уу? Эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүд, Үйлдвэржилтийн байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн амгаланг айлтгая. Бат-Эрдэнэ гишүүний асуултад дэс дараалалтайгаар хариулъя. Та үйлдвэрийн нийт хөрөнгө оруулалтын зардлыг асууж байх шиг байна. Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг 4 хэсэгт хувааж хэрэгжүүлж байгаа гэдгийг та бүхэн сая сонссон.

Тэгэхээр нэгдүгээр ажил бол 2021 онд эхэлсэн, 23 онд дуусна энэ жил. Энэ гэрээний, нэгдүгээр ажлын гэрээний дүн бол 97.8 сая ам.доллар, хоёрдугаар багц ажил нь үйлдвэрийн үндсэн технологийн байгууламжуудын ажил эхэлж байгаа хоёрдугаар багц ажлаар, өөрөөр хэлбэл атмосферийн нэрлэгийн байгууламж, вакуум нэрлэгийн байгууламж, толгой бүтээгдэхүүн ялгах байгууламж, нэмэх нь дагалдах, туслах бүх байгууламж баригдана. Жишээлэх юм бол 49 том агуулах сав, парк, 6 хий хадгалах сав, мөн ус цэвэршүүлэх байгууламж энэ тэр гээд

бүх дагалдах байгууламж ЕРС-2 дугаар гэрээний ажлын хүрээнд хийгдэнэ.

Гуравдугаарх дангаараа үйлдвэрийн цахилгаан станц, 2, 3 дугаар багц ажлын тендерт хоёуланд нь хамгийн бага үнийн саналыг Энэтхэгийн “Мега инженеринг” гэж компани ирүүлсэн. Үйлдвэрчний байнгын хорооны дарга Энхтүвшин гишүүн та санаж байгаа бол бид нар жилийн өмнө зөвхөн 2 дугаар багц ажил дээр зээлийн хэлэлцээрийн нийт үнийн дүнгээс их санал авчхаад бид нар бас сандарч явсан үе бий.

Гэхдээ Энэтхэгийн Засгийн газар, Энэтхэгийн “Экспорт-Импорт” банк энэ зээлийн ерөнхий хэлэлцээрийгээ дагаж мөрддөг журамд өөрчлөлт оруулж бид нар илүү өрсөлдөөн бий болгосноор хоёр, гуравдугаар багц ажил дээр нийтдээ 788 сая ам.долларын гэрээ байгууллаа. Ингээд эхний 1 дүгээр ажил 97.8, хоёр, гурав-788, ингээд дөрөвдүгээр багц ажлын тендер өнгөрсөн 22 оны 10 сарын 28-нд зарлагдаад сая өнгөрөгч 2 сарын 28-нд хүлээж авсан. Мөн хамгийн бага үнийн саналыг ЕРС-2, 3 дугаар багц ажил дээр сонгогдсон “Мега инженеринг” гэж компани өгсөн. 650 сая ам.долларын үнийн санал ирүүлсэн. 2 компани, 3 компани тендерт оролцсон. 1 нь бол техникийн шалгуураар тэнцээгүй. Хоёр дахь нь дараагийн хоёр дахь компанид 795 сая ам.долларын санал ирүүлсэн. Энэ “Мега инженеринг” гэж компани 648 сая долларын санал ирүүлсэн.

Ингээд бид нар Засгийн газарт бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, мөн Шадар сайдын ажлын албанд энэ мэдээллийг бол хүргүүлсэн байгаа. Ингээд нийтдээ энэ 4 багц ажлаас гадна төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээг бид нар 2019 онд 73.3 сая ам.доллаароор байгуулсан. Нэмэх нь манай үйлдвэрийн бүтээн байгуулалтын гүн боловсруулалтын технологийн байгууламжуудын 7 байгууламж нь гадаадын нефть химийн

салбарын технологи хөгжүүлэгч тийм үндэстэн дамнасан корпорацууд байдаг. Энэ компаниудтай жишээлэх юм бол Америкийн Нэгдсэн Улсын UFB, Би Францын Жэль, Италийн.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Алтанцэцэг даргад 1 минут нэмээд өгөөрэй 4 номерын микрофон.

Д.Алтанцэцэг: Баярлалаа. Одоо хурдан ярина. Ингээд нийт үнийн дүн бол тэрбум зургаан зуун тавин найм аравны есөн сая ам.доллар болж байгаа. Энэ чинь нарийвчилсан ТЭЗҮ-гийн үнэ орж байгаа, төслийн менежментийн зөвлөх орж байгаа. Лиценз эзэмшигчдэд 4 янзын гэрээ байгуулсан байгаа шүү дээ бид нар. Лицензийг нь хэрэглэх, дээрээс нь техникийг нь авах, зураг төслийг нь хийлгэх гэх мэтчилэн. Ингээд ер нь бол дахиад нэмэлтээр тэрбум хоёр зуун гучин зургаа, тэрбум зургаан зуун тавин наймын хооронд, дөрвөн зуун гучин долоо, найм орчим сая ам.доллар нэмэлтээр бол шаардлагатай болж байгаа. Энэ бол анхан тооцоолсноос 32 хувиар өсөж байгаа үнийн дүн. Энэ бол үнийн дүнд нөлөөлсөн 2 янзын фактор байгаа. Нэг нь техникийн өөрчлөлтүүд байгаа. ТЭЗҮ гэдэг бол зүгээр энэ үйлдвэрийг барих уу, үгүй юү гэдэгт хариулт өгдөг суурь судалгааны ажил. Инженерчлэлийн ажил эхэлснээс хойш бид нар дандаа Монголын нөхцөлд тааруулсан, үйлдвэрийн эдэлгээг сайжруулсан, түвэгшилтийг бууруулсан, үйлдвэрийн автоматжуулалтыг дээшлүүлсэн ийм олон.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Бат-Эрдэнэ гишүүн нэмж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Дамжуулах хоолойн үнэ чинь энэ дээр нэмэгдэж байгаа юу. Нэмэгдэнэ тийм үү? Үгүй, харин тэрийгээ хэлээд өгөөч дээ. Нийт бүтэн энэ төсөл чинь ер нь хэдээр орох юм бэ гээд тийм. Тэгээд товчхон товчхон хурдхан шиг хэдэн үгнүүдээ хэлээд явчхаач. Тэгээд дээрээс нь яг эндхийн Засгийн газартай холбогдсон бид

нарын үнэ өртөг чинь, гэрээ чинь хэд юм. Санхүүжүүлэх гэрээ хэд юм. Одоо бид нарын тэр хоолойтойгоо нийлээд хэд болчихож байгаа юм? Зөрөө нь хэд болчихож байгаа юм гэсэн. Тэгээд түрүүний хэдэн асуултууд дээр бас хариулаад өгөөч.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон Алтанцэцэг дарга.

Д.Алтанцэцэг: Үйлдвэрийн нийт хөрөнгө оруулалтын зардлыг та сая сонслоо. Түүхий тос дамжуулах хоолойн байгуулах ажлыг Хятадын “Norinco International” гэж компани гүйцэтгэж байгаа. Суурь судалгааны ажлууд бүгд дууссан. Үйлдвэрийн талбай дээр эхний 10 км шугам хоолой л ирсэн байгаа. Барилга угсралтын ажил эхэлж байна. Зураг төслийг Канадын “Worley Parsons” гэж компани гүйцэтгэж байгаа. Түүхий тос дамжуулах хоолойн гэрээний үнийн дүн 388 сая ам.доллар энэ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас зарласан тендерт шалгарсан энэ компанийн ирүүлсэн үнийн санал 388, дараагийнх нь 602 сая ам.доллар ирсэн. 3 дугаар компани 650 сая ам.долларын тендер ирүүлсэн байгаа юм.

Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил бид нар 2026 он гэхэд дуусгахич ингээд төлөвлөгөөтэй ингээд бүх долоо долоо хоногээр ажлаа ингээд төлөвлөчихсөн ажиллаж байсан. Харамсалтай нь сая энэ асгийн газар энэ шинээр гарсан тогтоол энэ тэртэй холбоотойгоор та бүхэн мэдэж байгаа сая Аубакир гишүүн хэллээ.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Нэмж авах уу хариулт? Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон нэмээд 1 минут өгөөдхөөрэй. Алтанцэцэг даргад.

Д.Алтанцэцэг: Тэрбум хоёр зуун гучин зургаа, таны танилцуулга нь байгаа болохоор би бас давтаад яах вэ гэж бодлоо. Тэрбум хоёр зуун гучин зургаа сая ам.долларын зээлийн гэрээ

байгаа. Нэмэлт шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтын зардал нь 400 орчим сая ам.доллар байгаа юм. Тэр үнийг би хэлж мэдэхгүй байна. Зах зээлийн үнээр л гэж байдаг байх. Зах зээл. Түрүүн сая сайдын ярианд байсан зах зээлийн үнэ. Зах зээлийн үнээр. Гаралгүй яах вэ. Тооцно тооцно бүгд бүгдийг нь тооцно. Тийм. Бид нар энэ үйлдвэрийн газрын тос боловсруулах үйлдвэрийн өнөөдөр манайх жил болгон 1.2-1.5 тэрбум ам.долларыг газрын тосны бүтээгдэхүүн худалдаж авахад зарцуулж байгаа. Түрүүн үйлдвэрээс гарах бүтээгдэхүүн бол манай зах зээлийн 50 орчим хувийг.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Энэ газрын тосны үйлдвэрийн асуудалд энэ манай энэ Уул уурхайн яамны дэд сайд л хариуцаад байгаа юм байлгүй дээ. Бодвол жоохон мэдээллээ тодорхой болгоод ажил руугаа орсон нь дээр байх. Өөрийн чинь танилцуулгаас бол их ойлгоод байсан юм алга. Тийм.

Их Хурлын Байнгын хороонд танилцуулга хийж байгаа бол бас наад ажилдаа бэлдэж байгаад орж ирж байсан нь дээр байх гэж бодож байна. Байнгын хорооны дарга бас чиглэл өгч наад хариуцлага ярих ёстой юм байгаа бол ярих хэрэгтэй шүү дээ та нар. Тийм.

Нэг асуулт байна. Энэ тогтоолын төсөл байгаад байгаа юм. Монгол газрын тос боловсруулах үйлдвэр төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагаанд шаардагдах урсгал таслал тавиад хөрөнгө оруулалтын зардлыг 2024 оноос улсын төсвөөс санхүүжүүлэхээр тооцож, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэж тогтоолын төслийн энэ төсөл орж ирсэн байгаа юм. Тэгэхээр одоо захирал аа саяын таны яриад байгаа 400 орчим сая долларыг төсвөөс санхүүжүүлнэ гэсэн үг үү тээ? Ер нь бол энэ нь яг ямар учиртай

санхүүжилт яригдаад байгаа юм? Улсын төсвөөс хэр хэмжээний юм, юу санхүүжүүлэх гээд байгаа вэ гэдгийг л тодруулах гээд байна л даа.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон Алтанцэцэг дарга хариулъя.

Д.Алтанцэцэг: Дамдинням гишүүний асуултад хариулъя. Энэ компанийн урсгал зардал өмнө нь Хөгжлийн банкнаас санхүүжигдэж ирсэн юм. Хөгжлийн банкнаас компанийн урсгал зардал, үйлдвэрийн гаднах дэд бүтэц гээд барьчихсан байгаа шүү дээ 3, 4 янзын дэд бүтэц, тэгээд газрын тосны үйлдвэрийн хотхон гээд ийм 3 зориулалтаар бид нар Хөгжлийн банкнаас зээл авч байсан. Энэ зээл зогсчихсон юм. Түрүүний тэр 400 сая, тэрбум 658 сая болж байгаа гэдэг бол Энэтхэгийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хэмжээ. Үйлдвэрийг барихад зарцуулагдаж байгаа юм. Энэтхэгийн тал анхнаасаа та бүхний энэ газрын тос боловсруулах шинэ үйлдвэрийн салбар байгуулах гэж байвал энэ компанийнхаа урсгал зардал болоод дэд бүтэцээ өөрсдөө хариуцаарай Монголын Засгийн газар гэж хэлсний дагуу ингээд энэ бол тэр асуудал байгаа юм.

Хөрөнгө оруулалт гэдэг бол үндсэндээ манай хотхоныг барихад зарцуулах шаардлагатай үлдэгдэл санхүүжилт л байгаа юм. Хөрөнгө оруулалт. Тэрнээс манай компанийн урсгал зардлууд бол бидний өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлдэг нь энэ өнгөрсөн жилээс хойш доголдоод бид нар чинь хэцүүдлээ шүү дээ. Сая 1, 2 сард цалингаа тавьж чадахгүй. 10, 20 инженерээ алдлаа ийм байдалтай байгаа.

Т.Энхтүвшин: Дамдинням гишүүн тодруулъя.

Г.Дамдинням: Алтанцэцэг даргаа тэгэхээр энэ тогтоолын төсөл дээр

хөрөнгө оруулалтын зардлыг гээд ингээд тавьчихаар нийт хөрөнгө оруулалт гэж ойлгогдоно л доо. Тэгээд тодорхой л оруулах ёстой байх нэгдүгээрт. Та надад тоо хэлээ гээдхээч хэр хугацаанд урсгал зардал, тэгээд тэр таны ярьж байгаа тэр 3 хэсэг ажил дээр л хөрөнгө оруулалт хийх гээд байгаа юм байна шүү дээ тээ? Энэ зардалд нийтдээ хэдэн төгрөгийн ачаалал төсөв дээр ирэх гээд байгаа юм бэ л гэдгийг асуугаад байгаа юм. Тэгээд хэдий хугацаанд буцааж төлөх юм, өөрөөр хэлбэл олох юм?

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг нээгээрэй.

Д.Алтанцэцэг: Хөрөнгө оруулалтын зардал гэхээр тэгж ойлгогдож байж магадгүй. Тэгэхдээ манайх нөгөө компанийн өөрийнхөө төсөв төлөвлөгөөндөө урсгал болон хөрөнгө оруулалтын зардал гэж хуваадаг болохоор тэгж хэлж байгаа юм. Тэрнээс энэ үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зардал бол биш. Энэ манай компани бол бид нар үйлдвэр ашиглалтад оруулах ер нь тун дөхөж байгаа. Хэнд ямар комисс ажиллах вэ гэдэг дээр хүртэл ингээд бид нар бүтэц яриад явж байгаа шүү дээ. Хамгийн гол нь хүнд цаг хугацаа их шаарддаг инженерчлэлийн ажил дууслаа, төлөвлөлт хэнээр хийлгэх вэ гэдэг том том техникийн асуудлууд шийдэгдлээ. Тийм, манай урсгал зардал бол энэ жилийн хувьд 8 тэрбум байгаа. Хөрөнгө оруулалтын зардал хотхонд бол 35-аас 40 орчим тэрбум төгрөг хэрэгтэй байгаа юм. Манай компани бол 24, 25, 26 онд хэрэгтэй болох байх. Тэгээд үйлдвэр өөрөө ашигтай ажиллаж эхэлнэ. Хөрөнгө оруулалт бол яах вэ тийм, яах вэ улсын төсөвт улсын төсөвт. 3 жилийн хугацаанд. Тэрнээс үйлдвэрийн гаднах дэд бүтэц баригдчихсан шүү дээ. Баригдаад 19 онд ашиглалтад оруулсан.

Т.Энхтүвшин: Тогтоолын төсөл дээр зарчмын зөрүүтэй санал авна. Та бүхэн маань саналаа өгөөрэй. Батлут гишүүн.

Д.Батлут: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Газрын тос боловсруулах үйлдвэр ч одоо 25 онд ашиглалтад орох ёстой байл уу даа. Би тэгж санаад байна. Үгүй энэ байдлаараа бол энэ чинь орох юм уу нөхөд өө? Яг үнэндээ энэ ажил хариуцсан хүмүүсийн хариуцлагагүй байдлаас улбаалаад зүгээр ажил хэргийн шугамаар шийдчих олон асуудлууд энд тусгагдсан байна шүү дээ та бүхний тайланд. Тэр санхүүжилтийг нь больё, тэр гаальтай холбоотой асуудал, тэр татварын хөнгөлөлттэй холбоотой асуудал гээд зөндөө олон асуудал байна. Энэ бүхнийг шийдчих боломжууд байгаа гэж харж байгаа. Энэ бүхэн дээр ач холбогдол өгөхгүй, анхаарахгүй байгаад байгаа нь энэ ажил хариуцаж байгаа хүмүүс чинь тэгээд энэ нефтийн үйлдвэртэй болох асуудлыг дэмжиж байгаа юм уу? Эсвэл бүүр эсрэг ажиллаад байгаа юм уу, болгохгүй гэж ажиллаад байгаа юм уу энэ чинь. Би бүүр ойлгохоо байгаад байна. Уул нь энэ нефтийн үйлдвэр байгуулагдсанаараа дотооддоо бид нар бензин шатахуунуудаа гаргаад, дэлхийн зах зээлийн үнээс арай хямд төсөр шатахууны хэрэглээ бий болгоно, Монгол Улсын иргэн бүрд хүртээмжтэй ийм томоохон бүтээн байгуулалт болж байгаа гэж үзэж байгаа юм.

Гэтэл ингээд суудал бөглөөд сууж байгаа төрийн албан хаагчид нь энэ бодлогынхоо эсрэг ингээд ажиллаж байгаа мэт дүр зураг эсгээд байгааг чинь яг юу гэж ойлгох юм бэ? Яагаад энэ асуудал дээр сэтгэл гаргаж ингэж дэмжиж шийдэл гаргахгүй байгаа юм бэ. Сангийн яамны дүрэм, журамд нийцээгүй учраас зээл нь зогсчихсон, тэр зээлийнх нь хүү нь явагдаж байгаа, яваад байгаа бас тооцогдоод, хажуугаар нь нөгөө Сангийн яамны дүрэм, журамд нь нийцээгүй учраас зогсчихсон. Тэгэнгүүт үйл ажиллагаагаа явуулахын тулд, цалингаа тавихын тулд 10.9 хувийн хүүтэй зээл аваад тавиад явж байдаг. Үгүй ийм дампуу юм гэж юу байна. Хэн энэ хариуцлагыг нь хүлээх юм бэ хариулж өгөөрэй надад. Хэн энэ мөнгөний

алдагдлыг, энэ хүүгийн алдагдлыг хэн хүлээх юм бэ хариуцлагыг нь. Тэгээд гааль дээр түр журам, горим гээд тоног төхөөрөмжийг нь оруулж ирээд жил болгоод буцаагаад гаргах юм гэнэ. Тэгээд буцаагаад дахиж оруулж ирэх юм уу. Ёо нээрээ би ерөөсөө ойлгохгүй байна би. Тэр тоног төхөөрөмж энэ урт удаан хугацаанд хэрэгжих төсөл гэж ойлгож байгаа. Яагаад энэ Гаалийнхан, Сангийн яамныхан энийг ойлгохгүй байгаа юм бэ. Би бол бүүр энэ нефтийн үйлдвэр барихын эсрэг энэ ажиллаад байгаа юм уу гэж ойлгочихлоо шүү дээ энэ байдлаараа. Ингээд жил болгон мэдүүлж, гаальд мэдүүлээд тоног төхөөрөмжөө оруулж ирдэг, буцаагаад жилийн дараа буцаагаад ахиад оруулж ирдэг. Хэдэн сард нь энэ ажиллах юм бэ. Энэ чинь зуны 3 сард л бид нар бүтээн байгуулалтын ажил хийдэг шүү дээ үндсэндээ. Үгүй тэгээд хэдэн сард нь энэ тоног төхөөрөмжөө нааш цааш нь зөвөрлөж ачуулж гаргаж, оруулж ирээд хэдэн сард нь ажиллаж, яаж бүтээн байгуулалтаа хийх гээд байгаа юм? Энэ эрүүл ухаан байна уу энэ Сангийн яам, Гаалийн газрынханд.

Т.Энхтүвшин: Батлут гишүүнд 1 минут нэмж өгье.

Д.Батлут: Үйлдвэр нь баригдаж байдаг. Хүний нөөцөө бэлтгэх гээд байдаг. Хүний нөөцгүй энэ үйлдвэр чинь яаж ашиглалтад орох бэ, ажиллах юм бэ? Тэр Ашигт малтмал, газрын тосны газрынхан яагаад тэр хүмүүсийн асуудлыг шийдэхгүй байгаа юм? Энэ асуудлуудыг бүгдийг нь цогцоор нь авч үзэж энэ Байнгын хорооноос гарах тогтоол дээр нэлээн тодорхой зүйлүүдийг зааж Засгийн газарт чиглэл өгөхгүй бол болохгүй байна нөхөд өө. Энэ арай дэндэж байна гэж ойлгож байгаа. Тэгээд тэр хариуцлагыг хэн хүлээх юм? Надад хариулж өгөөрэй.

Хоёрдугаарт нь энэ технологийн хувьд баахан олон гаднын компаниуд байна. Жишээлбэл устөрөгчийн үйлдвэр Италийнх гээд л, хүхэр ялгагч Францынх,

бензин боловсруулах тэр Америкийн Нэгдсэн Улс гээд, Голландын компаниуд байна. Энэ компаниудын хооронд технологийн ямар нэгэн зөрчил байгаа юу. Энэ тал дээр хариулт өгөөч. Хоорондоо мэдээж уялдаа холбоотой ажиллах ёстой шүү дээ энэ юмнууд чинь тийм ээ? Энэ дээр техникийн ший.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Ажлын хэсэг. Ажлын хэсгийн дэд сайд. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон дэд сайд хариулаарай. Дараа нь ажлын хэсгийн 4 дүгээр микрофон Алтанцэцэг дарга гээд. Ажлын хэсгийн 1 номер микрофон нээгээрэй.

Ч.Хишигдалай: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Уул уурхай, хүнд үйлдвэрээс Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Хишигдалай байна.

2023 оны 3 сарын 20-ны өдөр Засгийн газрын 82 дугаар тогтоолоор “Газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг “Эрдэнэс Монгол” компанид шилжүүлсэн байгаа. Яагаад шилжүүлсэн бэ гэвэл төслийн үйл ажиллагааг анх эхлүүлэхэд Хөгжлийн банкнаас бусад төслийн урсгал зардлыг санхүүжүүлэх зорилгоор зээлийн шугам нээсэн. Уг зээлийн шугам маань нийтдээ 250 орчим тэрбум төгрөгийн зээл авах эрхтэй байсан. 2023 оны 4 сард хугацаа дуусахаар байсан. Төсөл үргэлжлэх явцад КОВИД-той холбоотой төслийн үйл ажиллагаа маань тодорхой хугацаагаар саатсан. 23 оны 4 сар болсон. Зээл эргэн төлөгдөх асуудал сөхөгдөж ирсэн учраас энэ “Эрдэнэс Монгол” компанид хувьцаа эзэмшигчийн эрхийг шилжүүлснээр төслийг цаашид үргэлжлүүлэх урсгал зардлыг шийдээд явах боломжтой гэж үзээд Засгийн газраас уг шийдвэрийг гаргасан байгаа.

Гааль болон тэр татвар бусад асуудлаар бол Сангийн яамнаас бас тодорхой хариултууд, дүрэм журамтай

холбоотой хариултуудыг өгч байгаа. Бид нар бол бас асуудлыг шийдүүлэх гэж албан бичгээр болон албан шугамаар уулзаж асуудлуудыг ярилцаад явж байгаа.

Сургалтын асуудал бол Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах техник, эдийн засгийн үндэслэл дээр тус үйлдвэрийг барьж байгуулж байгаа компаниуд өөрсдийн технологийн барилга байгууламж дээр ажиллах мэргэжилтнүүдийг дадлагажуулах, сургалтад хамруулах зардлыг бас тусгаж өгсөн байдаг. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьд бол бас өөрсдийн санаачилгаар Шинжлэх ухаан, технологийн их сургуультай хамтран ажиллаад тодорхой тооны хүмүүсийг Шинжлэх ухаан, технологийн их сургууль бас сургаж байгаа. Эхний оюутнууд бол элсчихсэн. Ашигт малтмал, газрын тосны сургалтын сангийн зардлаас санхүүжилтээ аваад сураад явж байгаа. Энэ санхүүжилтийг цааш нь нэмэгдүүлж суралцагчдын тоог нэмэгдүүлэх талаар бас тодорхой ажлуудыг хийгээд явж байгаа. Ийм байна.

Т.Энхтүвшин: Ажлын хэсэг 4 дүгээр микрофоныг өгөөрэй. Алтанцэцэг.

Д.Алтанцэцэг: Батлут гишүүний үйлдвэрийн технологитой холбоотой хэсэгт хариулт өгье. Газрын тос боловсруулах үйлдвэрийн боловсруулах технологийн байгууламжууд бүгдээрээ лицензтэй байдаг. Тэр эхний 3 хэлсэн 2 дугаар багц ажлын хүрээнд хэрэглэгдэх энгийн үндсэн технологийн байгууламж бол Энэтхэгийн “Engineers India” компанийнх нь өөрийнх нь лицензээр хийгдэж байгаа. Үлдсэн 7 байгууламжид бид нар тендер зарладаг. Энэ процесс маш их уддаг. Жил хагас, 2 жил шахам үргэлжилдэг. Бараг зураг, төсөл хийж, тооцоо хийж байгаад сонгодог юм байна лээ. Бас бид нар анх удаагаа л ийм юмтай нүүр тулсан. Ингээд лицензгүйгээр бол хийхгүй. Тэгэхээр бид нар хэний лицензээр хийх вэ гэдэг ийм юуг олон улсад нээлттэй тендер зарлаад,

технологийн хөгжүүлэгч компаниуд оролцоод шалгарсан нь эдгээр компани юм.

Тэгээд энэ компаниудын хийх үүрэг нь юу гэхээр өөрсөд өөрсдийнхөө үйлдвэрийн технологийн дандаа нууцтай байдаг, өөрсдөө зохиодог, бид нар тэр лицензийг ашиглах гэрээг, дээрээс нь тэр нууцыг хадгалах, дээрээс нь заавал өөрсдөөс нь авдаг технологийн нэг хэсэг ч тоног төхөөрөмжүүд бий. Ийм ингээд дээрээс нь манай хүмүүсийг тэр технологитой байгууламж дээр сургах гэсэн ийм 4 янзын гэрээ хийгээд ажилладаг. Ямар ч үйлдвэр ингэж баригддаг. Эдгээр байгууламжуудыг барья л гэвэл. Хоорондоо тийм зөрчилтэй юм байхгүй.

Яагаад гэвэл бүгдээрээ нийтлэг тийм ерөнхий, суурь инженерчлэлийн ажил дээр тулгуурлагдаж хийгдэж байгаа учраас хоорондоо зөрчилдөх ийм асуудал бол байхгүй.

Т.Энхтүвшин: Батлут гишүүн нэмээд асууя.

Д.Батлут: Оруулж ирж байгаа материалууд ингээд зөрүүтэй байдгаа болимоор байна. Энэ Ашигт малтмалын, газрын тосны газраас энэ суралцаж байгаа хүмүүстэй холбоотой төлбөрийг шийдэхгүй байна гэсэн. Одоо бол дэд сайдын хэлж байгаагаар шийдэж байгаа гэх юм. Энэ холбогдох хүмүүсийн хариулж байгаагаар. Энэ дээр ахиад тодорхой болгоорой гэж хэлье.

Тэгээд Хөгжлийн банкнаас шугам нээгээд, тэгээд зээл олгоод явж байгаа гээд тэр нь тэгээд л тийм удааширсан зүйлүүд, энэ ажлыг гацаасан зүйлүүд л болоод байна л даа. Би Хөгжлийн банкны ажлын хэсэгт орж байсан. Сонсголын ажлын хэсэгт. Хөгжлийн банкныхан хувийн компаниуд зээл өгөхдөө юун дүрэм журам өөрсдийн тэр гарсан хууль тэрийг мөрдөхтэйгөө манатай. Маш их том давуу талууд бий болгоод янз бүрийн

асуудал үүсгээд, зээлээ олгочихсон байдаг.

Төр үндэсний эрх ашигт нийцсэн томоохон хөрөнгө оруулалт хийх гэхээр дүрэм, журам яриад байдаг юу гэж ойлгох юм бэ энэ чинь. Тэгээд хурдан энэ ажлуудаа хийх хэрэгтэй шүү дээ энэ чинь. Энэ холбогдох яаманд хариуцлага хүлээх тэр хүмүүстэй холбоотой асуудал дээр надад ахиад хариулт өгөөрэй. Энэ зээлтэй холбоотой гацаагаад байгаа зүйлүүд юунаас болсон юм, түүнтэй холбоотой.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Алтанцэцэг тодорхой асуугаад байна шүү дээ. Юунаас болоод гацаад байна? Энийг дараалаад хэлээд өгөөч гэдэг асуудлыг л Батлут гишүүн хөндлөө. Алтанцэцэг 4 номерын микрофон өгөөрэй.

Д.Алтанцэцэг: Хөгжлийн банкны тийм. Энэ Хөгжлийн банкны зээл бол 2018 онд авч эхэлсэн цагаас хойш бид нар яриагүй газар байхгүй. 11.89 хувийн хүүтэй зээлээр бид нар 4 жил энэ компани ажилласан.

166 тэрбум төгрөгийн зээл аваад хуримтлагдсан хүүгийн хэмжээ 2022 оны сүүлийн байдлаар 63, 64 тэрбум төгрөг болсон. Энэ бол ирээдүйд хөл дээрээ тэнцэж ядаж байгаа үйлдвэр, шинэ үйлдвэрийг ер нь бол эдийн засгийн талаас нь харахад яав ч байсан ингээд буруу байсан. Бид нар энэ хүүг бууруулж өгөөч, тэглэж өгөөч. Тэглэхгүй юм гэхэд бууруулж өгөөч. Эс үгүй бол өөр хямд эх үүсвэрээ санхүүжүүлэх боломж юу байна гэхээр үнэхээр энэ маш их олон дүрэм, журам мөрдөх шаардлагатай. Бид өөрсдөө

Т.Энхтүвшин: Нэмээд 1 минут өгөөдөх дөө. 4 номерын микрофоныг.

Д.Алтанцэцэг: Ингээд Цогтгэрэл гишүүнд дарга өөрөө хариулаарай. Энэ Хөгжлийн банкны зээл өнгөрсөн 3 сараас танай зээлжих барьцаа хөрөнгийн чинь хэмжээ хүрэхгүй байна гэж байгаа юм. Би энийг анхнаасаа ойлгоогүй. Маш их

газар бичсэн. Шинээр байгуулж байгаа юмандаа яагаад бид нарт барьцаа хөрөнгө нэхэж байгаа юм бэ? Энэ чинь төрийн, төрийн, төр засгийн, Монголын ард түмний өмч болох гэж байна. Жишээ нь шинээр хот барих юм бол энэ инженерийн дэд бүтэц барихдаа юуг барьцаалах юм бэ? Харин ч газрын тос боловсруулах үйлдвэр хүний нүдэнд харагдах, гарт баригдах зүйлүүд байгуулсан. Бид нар бол төмөр замтай, авто замтай, хотхонтой. Эд нарыг бүгдийг нь нэмээд барьцаа хөрөнгийн чинь хэмжээ хүрэхгүй байна гээд зээлийг зогсоогоод өнгөрсөн жил хотхон юу ч баригдаагүй. Ингээд 22 оны 12 сараас зээлийг бүрмөсөн зогсоогоод бид нар 2, 3 сар цалингаа тавьж чадахгүй тэгээд арга хэмжээ авч Эрдэнэс Монголд харьяалуулсан Эрдэнэс Монголоос бид нар цалингаа авахын тулд 10.9 хувийн хүүтэй ингээд зээлээр урсгал зардлаа.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Турилагатай бас салбарын өндөр мэдлэгтэй Цэндсүрэн дэд сайд бас асуудлыг оруулж ирж байгаа юм байна. Гэхдээ энэ асуудал бол Сангийн яам, Зам, тээврийн яам, Гадаад явдлын яам, Ерөнхий сайд, Ерөнхийлөгчтэй холбоотой асуудал яриад байна шүү дээ. Нарийн яривал. Бүүр нарийн яривал эзэн бие нь энэ 2023 оны 3 сарын 1-ний өдөр Засгийн газрын тогтоол гарсан. Тэр дээр “Эрдэнэс Монгол” ХХК бол энэ Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийг хариуцаж ажиллана гэхчхэн байгаа. Эзэн нь хаа байна, эзэн нь яагаад ирдэггүй юм бэ? Өнөөдөр төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Мөнхцэрэнд нь бүүр ингээд даалгачихсан энийг эрчимжүүлээч, гацаануудыг нь гаргаач гэхчхэн. Асуух ёстой хүн маань энд алга байна. Тэгээд би тодруулж. Ойлгож байна бидний мөрөөдөл шүү дээ энэ газрын тосны үйлдвэр гэдэг бол .Би маш их дэмждэг. Миний ч, бидний ч мөрөөдөл. Бүүр нарийн яривал Монгол Арлын намын мөрийн

хөтөлбөрийн энэ 24 онд ард түмэндээ очиход жоохон нүүр тахал ч магадгүй ганц юм нь л энэ. Чааваас энэндээ Засгийн газар нь өөрөө өөрийнхөө энэ мөрийн хөтөлбөрийн эсрэг ажилласан ийм л дүр зураг харагдаж байгаа. Би бол ичихгүй ярина. Би энийг бүтчихээсэй гэж дэмжиж, мөрөөддөг л хүн л дээ.

Тэгээд би хэдэн асуултууд тодруулчихъя.

Нэгдүгээрт энэ хамт олон энийг бүтээчих гээд л үнэхээр зүтгэж байгаа би ойлгож байгаа. Тэгээд анх бол 1 тэрбум 10.9 сая ам доллароор гэрээний нийт дүн батлагдсан.

Тэгээд бүүр техник эдийн засгийн үндэслэл бүх юм нь батлагдсан. Тэр чинь зүгээр тоо биш, техник эдийн засгийн үндэслэл гэдэг чинь шинжээчид, мэргэжилтнүүд баталдаг. Тэгсэн дараад нь 18 онд боловсруулсан энэ ТЭЗҮ-г зээлийн дүнгээр 30 орчим хувиар өссөөр байна гэж. 2, 3-хан жилийн дараа. 1 тэрбум 658.9 сая доллар болгосон. Нөгөө Англичууд Энэтхэгээс гарахдаа Энэтхэгүүдийг мөнгө хүйлэлтийн аргаараа дарамталж, спекуляц гэж байгаа шүү дээ. Тоглоом хийсэн шиг Энэтхэгүүд сайхан сэтгэлээр л тусалж байгаа л даа. Гэхдээ яагаад 400 сая орчим доллароор ТЭЗҮ-гээ нэмчхэв энэ Энэтхэгийн “Engineers India Limited” компани? Энэ дээр миний асуулт Монгол талаасаа шинжээч, эксперт гаргаж эднүүсийн энэ бодитой юмаа 2 жилийн дотор хэд жил гаруйхны дотор 400 сая доллароор тоног төхөөрөмжүүд нь өсчихсөн юм гэдэг дүгнэлт гарсан уу? Миний асуултад хариулж өгөөсэй. Ийм дүгнэлтийг зүгээр тэдний амаар шийдэж байгаа юм уу? Бидний зүгээс бие даасан шинжээчийн дүгнэлт гаргасан уу? Би энэ материалыг өнөө өглөө авлаа. Би хэд хэдэн search хийгээд Ашигт малтмалын энэ.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүнд 1 минут нэмж өгье. Ганбаатар гишүүний микрофоныг өгөөрэй.

С.Ганбаатар: Боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийн өсөлтийг харсан. Зарим нэг нь буусан, зарим нэг нь 5 хувиар л өссөн байна лээ. Тэгээд яг аль алин дээр юм тоног төхөөрөмж бүр дээр л ярьчихад энэ чинь 4 дүгээр ангийн хүүхэд л хийчихнэ л дээ уг нь. Тэгээд би ийм нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Мааш ноцтой асуудлууд энд гарч байна шүү дээ. 23 оны 3 сарын 1-ээр 82 дугаар тогтоол гарсан боловч тогтоолын заалтаар Сангийн яам, Гааль, бүүр Гадаад хэргийн яам, Экспорт-Импортын банкны зүгээс энэ асуудлууд дээр бүгдэд нь чагт тавьсан. Энэ дээр Улсын Их Хурал хариуцлага тооцох ёстой Засгийн газарт. Энэ дээр ямар нэгэн хариуцлага байх ёстой. Энэ чагт тавьснаас болж биднүүс 400 сая долларын ард түмний мөнгө шүү дээ. Бидний хүүхдүүд энэ 1.6 тэрбум долларыг төлнө шүү дээ дараа нь. Бидний хүүхдүүд төлнө. Тэгэхлээр энэ арчаагүй байдлыг хариуцлага хэнд тооцох вэ?

Гуравдугаар асуулт нь Тэр Norinco-той алаад.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон Алтанцэцэг дарга.

Д.Алтанцэцэг: Би эхний Ганбаатар гишүүнээ таны манай үйлдвэрийг үргэлж дэмжиж явдагт бас баярлалаа. Ганбаатар гишүүн маань манай компани дээр 2 ч удаа ирж байсан. Асуудлыг нэлээн сайн ойлгож байгаа. Тэгээд үнийн хувьд би эхний асуултад ер нь хариулт өгье. Газрын тос боловсруулах тэр 1 тэрбум ам.доллар гэдэг бол 2015 онд Энэтхэгийн Ерөнхий сайд Монголд ирэхдээ тэр ийм төсөлд гээгүй. Монгол Улс хөгжлийнхөө төсөлд зориулж 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийг Энэтхэгийн Засгийн газраас авч болно гэсэн ийм юу тавьсан байгаа. Тэгээд 2017 оны 2 сард Засгийн газар энэ зээлийн хөрөнгөөр

газрын тос боловсруулах үйлдвэр барья гэж шийдвэрлэсэн.

Ингээд ТЭЗҮ 17 оны 9 сард эхлээд, 18 онд бол бодоход хамгийн бид нар багаар бас шахаж бодож байсан л даа тэр үед .Тэрбум хоёр зуун гучин зургаа болсон юм. Ингээд Энэтхэгийн Засгийн газар бол 236 сая долларын нэмэлт зээлийн шугам нээгээд ийм тоотой явж байсан. Гэтэл одоо бид бүгд мэдэж байгаа. Ганбаатар гишүүнээ нэгдүгээрт энэ 2 шалтгаанаас болж ингэж үнэ бол өссөн.

Нэгд техникийн өөрчлөлтүүд байгаа. Бид нар бүгдийг нь жагсаагаад биччихсэн. Бүгдийг нь Энэтхэгийн тэр техник эдийн засгийн үндэслэлийг хийсэн компани, манай компанид бид нар бол нягт өдөржсінгөө хамт ажилладаг өдөр болгон. Тэгээд бид нар бол энэ өөрчлөгдсөн юмнуудаа тухай тухайн үедээ ингээд хүснэгтээр гаргаад, ингээд өдөртөө судартай ингээд гаргаад яваад байгаа. Жишээлэх юм бол тэр 49 агуулах савны чинь танкнуудын дээврийг нь зөвхөн дан дээвэртэй байсныг бүгдийг нь давхар болгосон. Тэр нөгөө бид нар дандаа ирээдүйд удаан ашиглах ашиглалтыг сайжруулах тэр элэгдэл, хорогдол, ажиллагааны төвөгшил энэ тэр гээд олон юм бид нар өөрчилсөн шүү дээ. Ер нь аягүй их манай талаас гарсан нь үнэн. Тэр говийн нөхцөлийн тэр элсэн шүүрганаас болж бид нар давхар дээвэртэйгээ. Тэр чинь 50 танк сав дээр тэгэхэд өөрчлөгдөж байгаа юм. Жишээлэх юм бол бид нар тэр Дэлхийн банкны тэр агаарын бохирдлын тэр нормыг хангахын тулд цахилгаан станц дээр нэмэлт том нокс төхөөрөмж тавьсан. Тэр аягүй үнэтэй байсан. Бид нар усны нөөцийн саваа газар дээр байсныг газар доор болгуулсан. Тэрнээс өөр аргагүй байсан юм.

Ингээд техник эдийн засгийн үндэслэл гэдэг бол ерөнхий тийм суурь судалгаа. Инженерийн үе шатанд манай талын хүсэлтийг гарсан тийм техникийн өөрчлөлтүүд байгаа юм. Нэмэх нь

КОВИД-ын цар тахлын үед одоо энэ улсууд чинь бүх төрлийн бараа материалын үнэ өссөн. Монголчууд хүртэл өнөөдөр манай энэ хотхон барьж байгаа хүмүүс төсвөө 2 дахин нэмчхээд л бид нараас мөнгө шаардаад сууж байгаа. Харин бид нар энэ Энэтхэгийн Засгийн газар олон янзын арга хэмжээ авсны үр дүнд харьцангуй өрсөлдөөнийг бий болгож байж гайгүй үнэ авсан. Бид нар аймшигтай үнэ авсан үе бий. Энийг Тэмүүлэн гишүүн та мэдэж байгаа. Үйлдвэрчний байнгын хорооны Энхтүвшин дарга та мэдэж байгаа. Бид нар ямар хүнд байдалтай байлаа? Энэ Энэтхэгийн зээлийнхээ хэлэлцээрийн дагуу бол зөвхөн Энэтхэгт бүртгэлтэй компани манай энэ тендерт оролцох ёстой. Бид нар өнөөдөр өөрсдөө тоогоо бодоод, материалаа бодоод, төсвөө зохиогоод энүүгээр бид нар манай компани барилаа гэдэг ийм систем биш. Энэ чинь тийм компаниуд оролцоно энэ тэр гэсэн. Бид нар ерөнхийдөө хүний бас юунд харьцангуй.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 2 дугаар микрофон дэд сайд.

О.Цэндсүрэн: Маши чухал асуулт асуулаа. Техник, эдийн засгийн үндэслэлтэй холбоотой. Аливаа энэ томоохон төслүүдийн Техник, эдийн засгийн үндэслэл маш чухал. Техник, эдийн засгийн үндэслэлийн хүрээнд ажил нь хийгдэж байна уу, үгүй юү гэдэг дээр хяналт тавьж ажиллаж байх ёстой. Засгийн газрын 82 дугаар тогтоолын дагуу энэ төслийн төсөлд хяналт өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллаж байх чиг үүргийг “Эрдэнэс Монгол” компани хүлээсэн байгаа.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ 2018 онд батлагдсан. Ажил хариуцсан “Эрдэнэс Монгол” компани 18 оноос хойш 5 жил болчихсон.Одоо манай яамны дэргэдэх Эрдэс баялаг мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар 5 жилийн дараа буюу энэ онд Техник эдийн засгийн

үндэслэлийн тодотголыг оруулж ирэх шаардлагатай. Ганбаатар гишүүнд энэ “Эрдэнэс Монгол” компани газрын тос боловсруулах үйлдвэрийн компаниас оруулж ирэх Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголын явцын талаар гарсан шийдвэрийн талаар тухайн үед нь танилцуулах болно.

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүн нэмээд асуух уу?

С.Ганбаатар: Монголын ард түмэн нефть боловсруулдаг л мөрөөдлөө биелүүлчих гээд л асуугаад байгаа ухаантай шүү дээ. Энэ улс төржих сэдэв ч биш л дээ. Гэхдээ л гомдмоор юм. Энэ бидний мөрөөдөл дээр л тоглож байна л даа. Энэ хамт олон нь үнэхээр зүтгэж байгаа. Миний тодруулах гэж байгаа 2 дугаар зүйл бол Газрын тосны тухай хуульд энэ протоколд Дачин Тамсгаас л нефть авахгүй бол манай энэ тосны үйлдвэр ажиллахгүй. Тэгээд энэнтэй гэрээ байгуулаагүй, одоо хүртэл таг. Энэ чинь Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хоёрын л асуудал шүү дээ энэ чинь. Газрын тосонд Дачин Тамсаг дээр очоод ярих юм бол зүгээр хэн ч ярихгүй. Хятадын Засгийн газартай томчуултай нь ярьдаг яриа. Энэ дээр ажлаа хийгээгүй байна.

Хоёрдугаарт ер нь Элчин сайдын яамаар нь дамжуулаад хэд хэдэн газруудад энэ дээр хөрөнгө оруулалт хийхийг би санал болгосон. Хэн ч ирээгүй гэж. Ашиггүй болж хувирч байна шүү дээ. Хөрөнгө.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүнд нэмээд 1 минут өгчих.

С.Ганбаатар: Тийм газрын тосны үйлдвэр нь хөрөнгө оруулалтыг татахын тулд хэд хэдэн орны Элчин сайдын яамаар дамжуулан газрын тосны мэргэжлийн компаниудад хандсан боловч хайгуул, үнэлгээ, бүтээн байгуулалтын ажилд их хэмжээний хөрөнгө оруулалт хийх санал ирээгүй гэж байгаа юм. Газрын тос гэдэг бол өнөөдөр

стратегийн, тусгаар тогтнолын хамгийн ашигтай бизнесийн нэг. Энэ төсөл ямар ч ашиггүй байна, сонирхолгүй байна гэдэг бол бараг түрүүн тэр Хөгжлийн банкныхан чинь зээл өгөхөөс татганаад, ингээд хулганаад байгаа чинь цаанаа бас учиртай байх талтай.

Тэгэхлээр энэ дээр тэр хариуцаж байгаа энэ хүмүүс бол ажлаа хийх гэж зүтгэж байгаа. Хариуцаж байгаа Эрдэнэс Монгол. Энэ тал дээр дүгнэлтээ хийгээд, Засгийн газар, Ерөнхий сайд, Ерөнхийлөгч энэ холбогдох хүмүүс нь Хятадтай очиж яриагаа хийгээч гэдэг ийм маш энгийн байр суурийг л би хэлээд байна шүү дээ. Тэгэхлээр энэ дээр бол би сая саналаа хэллээ.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн нэгдүгээр микрофон уу? Хэн хариулах юм? ажлын хэсгийн 4.

Д.Алтанцэцэг: Ганбаатар гишүүний саяын хэлсэн зүйл суулт гэхээсээ илүү шаардлага байна. Энэ энэ бол туйлын зөв. Ер нь бол бид нарт үйлдвэрээ ашиглалтад оруулах цаг хугацаа ойртож байгаа, үргэлж санаа зовж байгаа хамгийн том асуудлуудын нэг түүхий тосны асуудал байгаа. Ингээд бид нар мэдээж дүрэм журмынхаа дагуу тодорхой хугацаа заагаад гаднын компаниудад та бүхэн сая хэлж байна сонирхсон компани байгаагүй. Гэтэл энэ зүүн хойдын бүс нутагт газрын тосны резервуар хураагуур сав газрыг хамгийн сайн ойлгож амжилттай хайж, хайж олборлож байгаа компани Дайчин компани. Тэгээд Дайчин компанидаа хандахаас өөр аргагүй болсон.

Яагаад гэхээр энэ Давст 31 гээд манай компанийн олгосон талбай чинь хуучин Дайчин компанийн хайгуул хийж байгаад хайгуулын хугацаа нь дуусаад Засгийн газарт буцаагаад өгчихсөн талбай байдаг юм. Тэгээд энд бол Ёндон сайд уул уурхайн сайд байхдаа бас чиглэл өгөөд бид нар Дачин компанийн нэлээн

хэдэн хэлэлцээр бол эхлүүлчихсэн байсан.
Гэхдээ.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгөөрэй. Нэмээд 1 минут.

Д.Алтанцэцэг: Манай компанийн зүгээс Уул уурхайн яамаар дамжуулаад, Гадаад хэргийн яамаар дамжуулаад яг Ганбаатар гишүүний хэлсэн шиг Ерөнхий сайд, Ерөнхийлөгчийн энэ хөрш орнуудад хийх айлчлалуудад бид нар энэ дээд түвшний буюу Дачин компанийн дээд талын Хятадын газрын тосны үндэсний корпорац, Дачин Ойлд гээд толгой компанид нь хэлж өгөөч, манай компанид хөрөнгө оруулалтын асуудлыг шийдүүлж өгөөч гэсэн асуудлыг дандаа тавьж байсан.

Яагаад гэхээр Монголд ажиллаж Байгаа “Дайчин” компани та нартай хамтарч ажиллахад бэлэн байна, онцлог нь хөрөнгө оруулалт хийхийг манай толгой компаниуд шийднэ энийг та нар төр засгийнхаа түвшинд хэлүүлээрэй гэдэг юм. Тэгэхээр бид нар бас энийг манай төр засгийн байгууллагууд энийг онцгойлон анхааралдаа аваасай гэж хүсэж байна. Батцэцэг сайдад би хоёр ч уулзаж хэлж байсан. Энийг бол Засгийн газрын хуралдааны үеэр ч бас ярьж байсан ийм асуудал байгаа. Гэрээ хийх хэрэгтэй Хятадын талтай.

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүн болсон уу? Би 2, 3 асуулт асууна. Энэ удахгүй төсвийн тодотгол болох гэж байна. Монгол газрын тос боловсруулах төрийн өмчит хязгаарлагдмал компани маань урсгал зардлаа төсөвт суулгаж чадаж байгаа юу? Одоо “Эрдэнэс Монгол” дээр л яваад байна шүү дээ.

Ер нь юу гэдэг юм Монгол газрын тос энэ төрийн өмчит компанийг яг хэн хариуцаад байгаа юм? Шадар сайд хариуцаад байгаа юм уу, Уул уурхайн яам хариуцаад байгаа юм уу Эрдэнэс Монгол хариуцаад байгаа юм уу? Засгийн газар

хариуцаад байгаа юм уу гэдэг дээр тодорхой хариулт хэлээд өгөөч. Одоо ингээд хараад байхад хэн нь хариуцаж байгаа нь мэдэгдэхгүй. Анх бол бид нар юу гэдэг юм 4 сарын 25-нд Монгол Улсын Шадар сайдад газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын талаар мэдээлэл өгөөч гэдэг ийм асуултыг тавьсан. Тэгээд Шадар сайд 5 сарын 23-нд юу гэдэг юм мэдээллийг бид нарт хүргүүлсэн байж байгаа. Тэгээд өнөөдөр энэ Байнгын хорооны энэ мэдээллийг бид нар хэлэлцэж байгаа.

Гэтэл яг өнөөдөр өглөө ямар бичиг ирсэн гэхээр мэдээлэл хүргүүлэх тухай гээд Монгол Улсын Шадар сайдаас Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 82 дугаар тогтоолын 5 дахь заалтаар боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжийг эрчимжүүлэхийг Монгол газрын тос боловсруулах төрийн өмчит хязгаарлагдмал компанийн гүйцэтгэх захирал Алтанцэцэгт, ажлын явцын гүйцэтгэл зах зээлийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих ажиллахыг “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал Наранцогтод, мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Уул уурхайн, хүнд үйлдвэрлэлийн сайд Ж.Ганбаатарт даалгасгай.

Иймд газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын талаар тухайн мэдээллийг тухайн асуудлыг хариуцсан чиг үүрэг бүхий албан тушаалтнаас холбогдох танилцуулга мэдээллийг авах нь зүйтэй гэдэг ийм мэдээллийг ирүүлж байгаа байхгүй юу.

5 сарын 23-нд бид нарын тавьсан асуултад мэдээллээ хүргүүлчхээд яг юу гэдэг юм Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөр Байнгын хорооны хуралдааны шийдвэр гарчихсан байхад өнөөдөр ийм мэдээлэл ирүүлж байна.

Тийм учраас яг энэ газрын тосны үйлдвэрийг яг хэн нь хариуцаад байгаа юм? Энэ төрийн байгууллагууд чинь энэ нэгдмэл байхгүй ингээд уялдаа холбоо ер нь алдагдчихаад байгаа юм биш үү гэдэг ийм байдал бас ажиглагдаад байна.

Хоёр дахь асуудал нэлээн эрчтэй явсан газрын тос маань. Газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил ялангуяа Монгол Улсын Засгийн газраас хариуцаж байгаа ажлууд энэ хотхоны барилга байгууламж маань хэзээ дуусах юм? Энэ чинь одоо бараг 70 хувьтай баригдаад явж байгаа. Ингээд сүүлийн 2 жил хаягдчихсан. Энэ ер нь хэзээ дуусах юм, хөрөнгө мөнгө нь суусан юм уу? Энэ асуудал дээр бас хариулт хэлэх хэрэгтэй байна. Энэ асуудал дээр.

Гурав дахь асуудал энэ хайгуултай холбоотой ажил байгаа юм. Хайгуултай холбоотой. Бид нар энэ хуульд өөрчлөлт оруулаад “Монгол газрын тос” төрийн өмчит компани өөрсдөө талбайтай, өөрсдөө хайгуул хийх ийм бололцоо, боломжийг гаргаж өгсөн. Тэмүүлэн гишүүн бол яг энэ хууль дээр суусан. Тэгээд энэ хайгуул хийх ажлыг ер нь “Монгол газрын тос” төрийн өмчит компани нь хийж байгаа юу? Нөгөө өрөмтэй болох асуудал чинь шийдэгдсэн үү?

Тав дахь асуудал энэ боловсон хүчний асуудал дээр нэлээн анхаарах хэрэгтэй байна Энэ боловсон хүчний асуудлыг хэн хариуцаад байгаа юм? Уул уурхайн яам хариуцаад байгаа юм уу, Боловсролын яам нь өөрөө хариуцаад байгаа юм уу? Ашиглалтад орно энэ үйлдвэр нэлээн эрчтэй явж байгаа.

Ер нь бид нар харамсмаар зүйлүүд зөндөө байна шүү. Сая Дамжуулах хоолойн төслийн нээлт болсон. 2, 3 дугаар багц ажлын нээлт болсон. Үндсэндээ юу гэдэг юм яамдаас ганц ч төлөөлөл байгаагүй шүү дээ. Яамдаас. Сангийн яамнаас ч байгаагүй, Гадаад харилцааны яамнаас ч байгаагүй, Уул уурхайн яамнаас ч байгаагүй, Засгийн

газрын Хэрэг эрхлэх газраас ч байгаагүй. Үгүй ийм л нээлт хийж байна шүү дээ. Монгол Улсад хамгийн том бүтээн байгуулалт 21 дүгээр зууны аягүй хамгийн том бүтээн байгуулалт байхыг үгүйсгэх аргагүй. Монголчууд өөрсдөө газрын тосоо дотооддоо боловсруулъя, үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлъя, гаднаас хараат бус байя гээд ингээд төрийн өндөрлөгүүд нь ингээд зүтгээд байхад доод шатдаа ийм л байдалтай байж байна шүү дээ. Үнэхээр харамсалтай. Орон нутгаас сонгогдсоноороо Дэлгэрсайхан гишүүн бид 2 нээлт дээрээ оролцож үг хэлсэн. Ийм том бүтээн байгуулалтын ажил явж байхад үндсэндээ бол манай яамнуудаас ганц ч хүн алга байсан шүү дээ. Уул уурхайн энийг юу гэдэг юм ажлын уялдаа холбоог нь зохицуулах, энийг бүүр гардаж авах хэрэгтэй. Бараг юу гэдэг юм би бол та хэд бусад төрлийн хайгуул болон олборлолтоос илүүтэй Монгол Улсад хамгийн тулгамдаж байгаа асуудал энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн асуудал шүү. Ажлаа бас эрэмбэлж ажлаа хийх ёстой гэдэг дээр байр суурьтай байна.

Тэгээд хотхонтой холбоотой асуудал энэ боловсон хүчинтэй холбоотой асуудал 90 нь энэ “Газрын тос” төрийн өмчит компанийн энэ ажилчдын энэ цалин хөлсийг, цалин хөлстэй холбоотой, энэ хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг яагаад юу гэдэг юм “Эрдэнэс Монгол”-д өгсөн асуудал энэ дээр мэдээлэл өгөөдхөөч.

Уул уурхай Монгол газрын тос Алтанцэцэг захирал. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Ч.Хишигдалай: “Газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг “Эрдэнэс Монгол” компанид өгдөг үндсэн зорилго нь бол Хөгжлийн банкнаас авсан зээлийг төлөх хугацаа эхэлсэн, дахиж зээл олгох боломжгүй болсон. Үүнтэй холбоотой урсгал зардал санхүүжүүлэлтийг “Эрдэнэс Монгол”

компанийн Монгол улсын бусад томоохон төрийн өмчит компаниудыг толгойлж байдаг тодорхой хэмжээний орлоготой компанийн учраас уг санхүүжилтийг хариуцаж ажиллахыг үүрэг болгож манайх бол Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хувьцаа эзэмшигчийн эрхийг шилжүүлсэн байгаа.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хувьд бол газрын тос боловсруулах үйлдвэрийг мэргэжлийн удирдлага удирдлагаар хангаж ажиллах үүргийг хүлээсэн байгаа. Энэ үүргээ хүлээгээд ажиллаж байгаа.

Боловсон хүчний асуудлын хувьд бол техник, эдийн засгийн үндэслэл дээр тусгагдсан байгаа лицензтэй барилга байгууламж, техник технологийг барьж байгуулж байгаа компаниуд боловсон хүчнийг сургах үүрэг хүлээсэн байгаа.

Дээрээс нь бид Шинжлэх ухаан, технологийн их сургууль дээр тодорхой тооны оюутнуудыг өнгөрсөн намраас элсүүлээд сургалтын төлбөрийг нь даагаад явж байгаа. Тэгээд сургалтын төлбөрийн асуудал нэлээн удааширалтай байгаа. 7 хоногийн өмнө шийдэгдсэн байна лээ. Энэ бичгийн хариу бол өнгөрсөн 5 дугаар сард очсон учраас бас энэ дээр тодорхой мэдээлэл байхгүй байх шиг байна.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгөөрэй.

Д.Алтанцэцэг: Би аль асуултад нь хариулахаа бас сайн мэдэхгүй байж, манай компани чинь газрын тос боловсруулах үйлдвэрийг хариуцах Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсгийг 2020 онд Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан. Тэр Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсгийг бол татан буугдаагүй байгаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэ засаг солигдсонтой холбоотойгоор ажлын хэсгийн бүрэлдэхүүн бол өөрчлөгдсөн, татан буугдаагүй байгаа юм. Мөн саяхан бол энэ манай үйл газрын тос боловсруулах

үйлдвэртэй холбоотой тулгамдсан асуудлууд нэлээн бүүр ингээд газар авсны дараа мөн Ерөнхий сайдын захирамжаар сая өнгөрсөн 5 сард Засгийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг тэнд бол Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Уул уурхайн сайд, нарийн бичгийн дарга нь байдаг юм. Ингээд 4, 5-хан хүний бүрэлдэхүүнтэй ийм ажлын хэсэг байгуулсан. “Эрдэнэс Монгол”-д харьяалуулсан гэж яг үнэндээ бид нар Засгийн газар төр засагт мэдээлэл хүргүүлэх, Засгийн газар асуудлаа хэлэлцүүлэхдээ хаагуур дамжуулахаа бас тодорхой сайн мэдэхгүй байгаа.

Дараагийнх нь хотхон бол нийгэм эдийн засгийн маш их ач холбогдолтой ийм төсөл байсан юм. Онцлог нь энэ КОВИД, цар тахлын үеэр компаниуд энэ манай тээвэр ложистикийн асуудал асар их хүндрэл дагуулсан. Энэ нь хотхоны туслан гүйцэтгэгч компаниуд, гүйцэтгэгч компаниуд санхүүгийн бас нэлээн эрсдэлд орсон. Дахиад л Хөгжлийн банкны санхүүжилт ярья. Анхнаасаа л тасалдаж эхэлсэн, анхнаасаа л тэр бас тодорхой үүрэг гүйцэтгэсэн. Уул нь бол тийм бас бариад суучих боломж байсан. Яагаад гэвэл 2 үе шаттай баригдаж байгаа шүү дээ. Эхний үе шат нь үе шат ч яах вэ 2 хэсэгт хуваан зэрэг шахуу эхэлсэн хэр нь 1 дүгээр хэсгийн эхний барилгаа бол ашиглалтад орчихсон бид нар түүнийг эдийн засгийн эргэлтэд оруулаад ингээд өөрсдийнхөө зорилгынх нь дагуу ашиглаж байгаа.

Хайгуултай холбоотой та ярьж байна. Бид бол бас, хайгуултай холбоотой энэ хэсгийг манай Газрын тосны хайгуул, олборлолтын газрын дарга, доктор Буян-Арвижсих одоо хариулна.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 7 дугаар микрофоныг өгөөрэй.

Д.Буян-Арвижсих: Сайн байцаана уу? Тэгэхээр Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн хайгуул ашиглалтын газар Давст 31 талбай дээр

хайгуул хийж байгаа. Бид нар “Петрочайна Дачин Тамсаг” компанийн “Давст-31” талбайгаас авсан геофизикийн өгөгдлүүд дээр геологи, геофизикийн тайллын ажлуудыг хийж байна. Одоогийн байдлаар бид нар ер нь газрын тос агуулах өндөр магадлалтай 3 талбайг ялгачхаад байгаа. Энэ дотор 7,7 сая баррель ашиглах боломжтой газрын тосны эзлэхүүнийг тооцсон. Зөвхөн энэ дээр хайгуулын цооног өрөмдөж шалгаж үзэх шаардлагатай байгаа юм. Тэгэхээр энэний санхүүжилтийн асуудлыг шийдэж өгөх юм бо бид нар энэ зун ч гэсэн өрөмдүүлчих сонирхолтой байгаа.

Ер нь хайгуулын ажил маань хэтийн төлөвөө ингээд харах юм бол бид нар хайгуулын ажлыг одоогоос л ер нь эрчимжүүлэхгүй бол ерөнхийдөө оройтож байна шүү. Тэгэхээр энэ дээр маш сайн анхаарал хандуулаасай гэж та бүхнээс хүсэж байна.

Т.Энхтүвшин: Би түрүүн асуулт асуусан юм шүү дээ. Яг хэн хариуцаад байгаа юм бэ энэ газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтыг энэ дээр тодорхой хариулт хэлээд өгөөч. Яг хэн багцалж хариуцаж байгаа юм, хэн уялдаа холбоог нь хангаж байгаа юм, хэн энэ зээлтэй холбоотой энэ бүтээн байгуулалттай холбоотой асуудал дээр нь гүйцэтгэлийн хяналт тавьж байгаа юм. Энэ талаараа мэдээлэл өгөөдхөөч.

Ер нь сүүлийн үед юу гэдэг юм газрын тосны үйлдвэр дээр очиж танилцаж байгаа юу гэдэг юм яам, тамгын газраас байхгүй байгаад байгаа шүү. Яг эзэнгүйдчихсэн, төрийн өмчтэй компанийн захирал Алтанцэцэг гуай л явдаг, яамнууд нь бүгд хойшоо суучихсан, шийдвэр гаргадаг хүнгүй болсон. Энэ Хөгжлийн банкны асуудлаас болоод юу гэдэг юм энэ том бүтээн байгуулалт явж байсан зээл зогссон. Хөгжлийн банкны асуудал бол Монгол Улсад, Монгол Улсын хөгжилд цаашидаа хэрэгтэй ийм том бүтээн байгуулалтыг л санхүүжүүлэх ийм л эрх үүрэгтэй банк шүү дээ. Тэгээд энийг туйлшираад

зогсоосон. Яам нь энийг үргэлжлүүлээд өгөх талаар ямар ч санаа, санаачилга гаргаагүй. Ийм байдалтай л бид нар ажилласан.

Тэгээд 1 гүйцэтгэлийн гэрээ зураад явах гэхээр хүн болгон татгалздаг. Тэгээд газрын тосны бүтээн байгуулалтын ажил хэр түвшинд явж байгааг хэн ч мэддэггүй, очиж үздэггүй. Сардаа яваад 1 удаа үзэж болно шүү дээ энэ уул Уул уурхайн яам. Энэ эзэнгүй болгоод хаячихсан. Тэгээд яг хэн хариуцаж байгаа юм энийг багцаар нь энэ гүйцэтгэлийн хяналт, энэ явцын хяналтыг нь яг хэн хийж байгаа юм? Энэ дээр Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам хариулт хэлээдхээч.

Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгөөрэй.

О.Цэндсүрэн: Би Засгийн газрын 82 дугаар тогтоол хэлэх гэж байна. Энэ тогтоол дээр эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр “Эрдэнэс Монгол” компанийг тогтоогоод ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих үүргийг “Эрдэнэс Эм Жи Эл” -д өгсөн байгаа.

Тийм болохоор таны ярьж байгаа сая энэ зээлийн зарцуулалтын асуудлыг “Эрдэнэс Эм Жи Эл” хариуцаж байгаа гэж ойлгож болно.

Т.Энхтүвшин: Та хэд тэгээд энэ дээрээ анхаарна биз дээ. “Эрдэнэс Монгол” хариуцаж чадахгүй шүү дээ энэ мэргэжлийн байгууллагын асуудлыг. Тэгээд бүхэл бүтэн Уул уурхайн хүнд үйлдвэрлэлийн яам байж энэ асуудлыг бас та хэд өөрсдөө олж хардаггүй. Яаж “Эрдэнэс Монгол” хариуцаад явж чадах юм. “Эрдэнэс Монгол”-д чинь яг ийм мэргэжлийн хүмүүс байгаа юм уу? Байхгүй шүү дээ. Би Наранцогт даргатай уулзсан. Анхнаасаа л юу гэдэг юм бүтэц зохион байгуулалтын асуудал, санхүүжилтийн асуудлыг та хэд маш том алдаа хийсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчөөсөө авхуулаад энэ том

бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, хугацаанд нь дуусгая гэдэг ийм санаачилга гаргаад ажиллаж байхад та хэд бол бүх юмнаас зайлсхийж зугтсан. Ерөөсөө хойноос нь явдаггүйн жишээ л дээ.

2023 оны төсөвт суулгаж чадаагүй болохоор та хэд “Эрдэнэс Монгол”-д хүчээр өгсөн байна лээ. Энэ чинь бүхэл бүтэн Уул уурхайн байж энийг өөрсдөө хариуцаад 2022 онд нь энийг юу гэдэг юм төсөвт суулгая гээд. Төсвөөс санхүүжиж байгаа ийм нэгжийн байгууллага зөндөө л байж байгаа шүү дээ. Хөшигтийн хөндий гээд л байж л байна. Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүс гээд шууд шууд төсвөөс санхүүжээд явдаг байгууллагууд зөндөө л байж байна шүү дээ. Ийм тогтолцоог л хийгээд явах ёстой юмыг ажлаа цаг хугацаанд нь хийгээгүй, 2023 оны төсөв батлагдсан. Тэгээд “Эрдэнэс Монгол” руу хүчээр өгсөн асуудал байгаа юм байна лээ шүү дээ. Тэгэхээр энэ том бүтээн байгуулалт дээр та хэд өөрсдөө анхаарах хэрэгтэй. Цаашидаа тэр Ганбаатар гишүүний хэлдгээр бол юу гэдэг юм бид нар бас энэ Үйлдвэрчдийн байнгын хороон дээр энэ гааль дээр нь юу гэдэг юм энэ Сангийн яам, Уул уурхайн яам, “Эрдэнэс Монгол”, Гадаад харилцааны яамыг бүгдийг нь нэгтгэсэн ийм мэдээллийг, ийм хэлэлцүүлгийг ч тэгсэн зохион байгуулах шаардлагатай юм байна Хөгжлийн банк гээд.

Гаднынхан энийг дуусгачихъя, энийг нь хурдан явуулаад дуусгачихъя гээд санаачилгатай ажиллаад байхад бид нар өөрсдөө л доод шатандаа ингээд ямар ч санаачилга байхгүй ингээд л байж байна шүү дээ. Очиж үздэггүй, бүтээн байгуулалт нь ямар явцтай байгааг мэддэггүй. Тийм учраас энэ асуудал дээр онцгой анхаарахгүй бол тэр Тяньжинь дээр байж байгаа Замын-Үүдийн Эрэн дээр байж байгаа энэ бараа бүтээгдэхүүний чинь тэндээ байгаад гааль, НӨАТ-ын татвараас эхлүүлээд машин тоног төхөөрөмжийг буцаах асуудлаас эхлүүлээд энэ газрын тос

төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүжилтийн асуудлаас эхлүүлээд нөгөө урд нь Хөгжлийн банкаар санхүүжүүлээд явж байсан барилга байгууламж нь зогссон. Энийг гүйцээж дуусгах аас эхлүүлээд Монголын Засгийн газрын хүлээх энэ ажлууд орхигдсон байгаа юм байна лээ шүү. Энэ дээрээ бас нэлээн санаачилгатай, бас санаачилга гаргаж ажиллаарай.

Тэгээд гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшинээс Монгол Улсын Их Монгол Улсын Шадар сайдад хандан газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар тавьсан асуултын хариуг сонсож дууслаа.

11.49 цаг

Одоо Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12.4 асуулт тавьсан гишүүн шаардлагатай гэж үзвэл асуултын хариуг Байнгын хорооны хуралдаанд танилцуулж, тодорхой арга хэмжээ авах хүсэлтийг шийдвэрийн төслийн хамт Байнгын хорооны даргад уламжлах болно гэсний дагуу Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулсан байж байгаа.

Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэн тараасан байж байгаа. Энийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг та бүхэндээ танилцуулъя.

“Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын

Үйлдвэржилтийн байнгын хорооноос
ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай, Шинэ сэргэлтийн батал бодлого батлах тухай, Монгол Улсын Засгийн газрын 2020-24 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, Монгол Улсын Их Хурлын тогтоолд тусгагдсан Газрын тос боловсруулах үйлдвэр, байгуулах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор дараах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар Л.Оюун-Эрдэнэд чиглэл болгосугай.

1.Монгол “Газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн өмчит хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилладаг төрийн захиргааны төв байгууллагыг тогтоох.

Хэн хариуцаад байгаа нь мэдэгдэхгүй байна шүү дээ.

2.“Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагаанд шаардагдах урсгал зардал болон хөрөнгө оруулалтын газрын тосны, боловсруулах үйлдвэрийн дамжуулах хоолойн бүтээн байгуулалтаас бусад хөрөнгө оруулалтын зардлыг 2024 оны улсын төсвөөс санхүүжүүлэхээр тооцож, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Ажлаа эрчимтэй явуулья хэдүүлээ. Энэ төрийн өмчит компаниа ямар ч байсан төсвөөс шууд санхүүжүүлдэг болгоё. Хөрөнгө оруулалтыг нь бас шууд тавьж өгье гэдэг асуудлаар оруулсан.

3 дахь асуудал.Газрын тосны олборлолтын орд ашиглах үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнд заасан хэмжээнд хүргэх зорилгоор хайгуулын ажлыг нэмэгдүүлэх. Олборлосон төсвийг Монгол Улсад баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх. Мөн “Монгол Улсын Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хамтарсан хайгуул хийх талаар судалж, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн дээд шатын эрх бүхий байгууллагуудыг гэрээ, хэлцэл байгуулах ажлыг эрчимжүүлэх.

Түрүүн Ганбаатар гишүүн хэлсэн. Үйлдвэр ашиглалтад ороход тос дутагдана. Тийм учраас олборлож байгаа компаниудтай гэрээ хэлэлцээрээ яаралтай хийе гэдэг асуудлыг ингээж оруулсан байж байгаа.

4.Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдээр тасралтгүй хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газраас “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид олгосон талбайд хайгуулын ажлыг гүйцэтгэх, үүнтэй холбогдон гарах хөрөнгө, санхүүгийн асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.

Тав дахь асуудал.Газрын тос боловсруулах тухай хууль болон газрын тос боловсруулах үйлдвэр төрөөс дэмжлэг үзүүлэх журмын хэрэгжилтийг хангаж, үйлдвэрийн бүтээн байгуулалтад тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэн төслийн ажлыг эрчимжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллах.

Ийм 5 асуудал орсон байж байгаа.

Хоёрт нь бол энэ тогтоолын хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион

байгуулж хэрэгжилтийн талаар Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн байнгын хороонд 2023 онд намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшинд даалгасугай гэсэн ийм тогтоолын байж байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух асуух зарчмын зөрүүтэй санал хэлэх гишүүд нэрээ өгье. Эхлээд ямар ч байсан асуултаа асуугаад дараа нь. Батлут гишүүнээр тасаллаа. Аубакир гишүүн.

Т.Аубакир: Асуулт байхгүй. Нэгэнт Засгийн газарт чиглэл өгч байгаатай холбоотой зарим Засгийн газрын түвшинд буюу харьяа яам, агентлагуудын түвшинд зохицуулчих аягүй энгийн асуудлууд байгаад байгаа юм. Жишээлбэл түрүүн хэлсэн энэ бүтээн байгуулалттай холбоотой ашиглаж байгаа тоног төхөөрөмжийг түр горимд байршуулах асуудлыг Засгийн газар, гаальд буюу Сангийн яаманд чиглэл өгөх хэрэгтэй. Тийм учраас энэ тогтоол дээр би оруулах саналтай байна. Зарчмын зөрүүтэй саналаа биччихсэн байж байгаа.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад ашиглагдаж байгаа машин механизм, тоног төхөөрөмжийг бүтээн байгуулалтын хугацаанд байршуулах боломжийг бүрдүүлэх гэж байгаа юм. Энэ дээр мэдээж хэрэг бүрдүүлэлтийн горимууд өөрчлөгдөнө. Бүрдүүлэлтийн горимууд гааль дээр жишээлбэл 512, 515, 400,403 гэсэн горимууд байдаг юм. Дотоодын хэрэгцээнд гэдэг юм уу энэ чинь нэгэнт Монгол Улс нефтийн үйлдвэртэй болъё гэж байгаа юм чинь бид нар бүх боломжоо төр засгийн зүгээс шалтгаалах боломжуудыг ашиглах ёстой. 1 жил байршуулаад

дахиад 1 жил хугацаатай л сунгадаг байхгүй юу гаалийн горим. Энийг ерөөсөө бүтээн байгуулалтын хугацаанд байршуулж ашиглах боломжийг бүрдүүлж өг гэсэн чиглэлийг Засгийн газарт өгч байгаа юм.

Тийм учраас миний саяын гаргасан зарчмын зөрүүтэй саналыг тогтоол дээр тусгахыг хүсэж байна. Зарчмын зөрүүтэй саналаа би цаасаар биччихлээ. Ингээд газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад ашиглагдаж байгаа машин механизм, тоног төхөөрөмжийг бүтээн байгуулалтын хугацаанд байршуулах боломжийг бүрдүүлэх гэсэн ийм зарчмын зөрүүтэй саналаа гаргаж байгаа юм. Санал хураалгаж тогтоол дээр оруулахыг шийдэж өгнө үү гэж.

Т.Энхтүвшин: Аубакир гишүүний саналаа наашаа өгчих тийм ээ. Сүүлд нь уншаад санал хураачихъя. Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Засгийн газарт чиглэл өгөх тухай 1 дүгээрт протоколоор энэ 2023 оны 3 сарын 1-ний өдөр Монгол улсын Засгийн газрын тогтоол гараад “Эрдэнэс Монгол” компанид хариуцуулаад энэ бүүр Мөнхцэрэн гээд Ш.Мөнхцэрэн гээд ТУЗ-ийн даргад нь бүүр даалгаад, ингээд Наранцогтод бас даалгасан байна. Эрдэнэт гүйцэтгэх захирал Наранцогтод. Энэ бүүр ингээд Ерөнхий сайд өөрөө ингээд эзэнжүүлээд, биежүүлээд одоо 3 сар 6 хоног. Өнөөдөр 3 сар 6 хонож байна. Энэ хооронд юу хийсэн бэ, яагаад ингээд таг байгаа юм бэ юу ч хийдэггүй юм бэ гэдэг дээр хариуцлага тооцож тайланг нь Байнгын хорооныхоо шугамаар яаралтай авах ёстой гэдэг ийм зүйлийг протоколд оруулмаар байна.

Хоёрдугаар зүйл ер нь ийм том асуудал юм байгаа юм шүү дээ. Оюу толгойн гэрээ анхны хөрөнгө оруулалтын хэмжээ 1.4 тэрбум доллар байсан. Дараа нь 1.7 болсон. Одоо бид 1 тэрбум 658 сая

долларын тухай ярьж байгаа шүү дээ. Энэ чинь Оюу толгойн анхны хөрөнгө оруулалттай тэнцүү хэмжээний мөнгөн дүнтэй юм ярьж байгаа дараад нь Монголын хүүхдүүд, ирээдүй, бидний ирээдүй татвараараа төлөх мөнгө. Энэ ноцтой асуудал учраас энэ дээр ийм арчаагүй байгаад харамсаж байна. Тэгээд нэгдүгээрт “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани зохион байгуулалтаар хангаж ажилладаг төрийн захиргааны төв байгууллагыг тогтоох гэж байгаа дээр түрүүний ярьсан, гарсан санал саналтай санал нэг байна. Яг Сангийн яам, Зам, тээврийн яам, Гадаад харилцааны яам энэ дээр оролцоно шүү дээ. Энэ чинь том зээлийн асуудал яриад байгаа учраас би Сангийн яамыг ярьж байгаа юм шүү. Том зээл яриад байгаа байхгүй юу. 1.6, 1.7 тэрбум долларын зээл.

Хоёрдугаар зүйл. Монголын газрын тос боловсруулах үйлдвэр төрийн өмчит компани нь 24 оны төсвийн тухай хуулийн төсөлд мөнгө нэмж оруулна гэж байгаа юм. Энэ дээр миний оруулах гээд байгаа санал гэвэл зарчмын зөрүүтэй санал бол тэр 30 хувь нэмэгдээд байгаа 400 тэрбум доллар дээр хөндлөнгийн экспертийн дүгнэлтийг заавал Монголын талаас гаргах хэрэгтэй. Зүгээр тэр Энэтхэг компанийн амаар шийднэ гэж байх ч үгүй. Би энэ дээр 400 тэрбум доллар дээр голоо цохиж байна. 400 сая доллар шүү. Чөрт ёстой нэг бүүр дэндүү их мөнгө байхгүй юу, дэндүү их мөнгө. Хэдэн мянган сургууль, цэцэрлэг. Энэ дээр оруулах хэрэгтэй. Энэ дээр заавал хоёрдугаар заалт.

Гуравдугаарт энэ газрын тосны тал дээр тэр газрын тосны тэр Дачин Тамсагаас л гэрээ байгуулж нефтиэ авна гээд Газрын тосны хууль дээр нь ч байгаа. Энэ ингээд эзэнгүй хаячихсан. Дээд шатны эрх бүхий байгууллагатай гэрээ хэлцэл байгуулах зарчмын ажлыг оруулах. Энэ дээр нэр заагаач Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ, Ерөнхийлөгч Хүрэлсүх

бүс нутгийн гэрээнд юм уу, улс хоорондын.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүнд нэмээд 1 минут өгөөрэй.

С.Ганбаатар: Энэ 3 дугаар асуудал дээр тэр Дайчин Тамсагтай нефтийн байгуулах гэрээ. Зарим талаар бүүр Барна уулаас гэрээний түүхий нефть авна ч гэж ярьж байсан. Ингээд энэ олон улсын асуудал болоод явчихсан юман дээр эзэн биегүй зүгээр л хэлцэл байгуулахыг эрчимжүүлэх гээд хаячхаж болохгүй. Энэ дээр Монгол Улсыг төлөөлж ярих хоёрхон хүн байгаа Ерөнхий сайд, Ерөнхийлөгч, эзэн биетэй нь оруулаад хугацаатай үүрэг даалгавар нь Их Хурлаас өгөх ёстой. Монголын ард түмнийг төлөөлж.

Тэгээд тавдугаарт нь Газрын тос боловсруулах тухай хууль болон газрын тос гээд баахан юм ярьснаа төслийг эрчимжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллуулах гэж ийм бөөрөнхий үг оруулмааргүй байна. Саяын зүйлүүдийг эзэн биетэй, тодорхой хугацаатай, мөнгөн дүнтэй оруулбал маш сайн.

Эцэст нь энэний биелэлтэд манай энэ Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо энэ анх удаа энэ чуулганаар байгуулагдсан гэж би ойлгож байгаа шүү дээ. Үйлдвэрч.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүний саналыг сонслоо. Протоколд сайн тэмдэглээрэй. Батлут гишүүн.

Д.Батлут: Санал гаргасан гишүүдтэй санал нэг байгаа. Дан ялангуяа энэ 3 дугаар заалт дээр энэ бүтээгдэхүүн хуваах гэрээнд олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд тэдгээрийн дээд шатны эрх бүхий байгууллагуудыг гэрээ хэлцэл байгуулах ажлыг эрчимжүүлэх гэж хаяж болохгүй. Бид нар газрын тосны үйлдвэр байгуулчхаад түүхий эдгүй сууж болохгүй шүү дээ

тийм биз дээ? Тэгэхээр энийг бид нар бүүр тодорхой болгож өгөх хэрэгтэй. Эзэн биетэй болгох хэрэгтэй.

Дээрээс нь байгууллагуудтай гэрээ байгуулах гээд бүүр эцсийн байдлаар ингээд төгс арга хэмжээ авахаар найруулгын шинж чанартай өөрчлөлтийг хийж өгөөч гэдэг санал байна. Ингэхгүй зүгээр эрчимжүүлэх гээд хаячхаж болохгүй. Эзэн биетэй болгоод төгс хийх тэр шийдэл дээр найруулгын шинж чанартай өөрчлөлтийг хийж өгөөч ээ.

Хоёрдугаарт нь бид нар газрын тосны үйлдвэр байгуулсны дараа мэдээж ажиллах хүчингүй, хүний нөөцгүй бол бас ингээд явахгүй болно. Тийм учраас бүтээн байгуулалтын ажилтай зэрэгцээд хүний нөөцийн асуудлуудаа нэн тэргүүнд явах ёстой. Би түрүүн асуулт асуусан. Энэ ажлын хэсгийн мэдээлэл дээр болохлоор ерөөсөө энэ сургуульд Ашигт малтмалын хэрэг, газрын тосны газраас энэ газрын тосны чиглэлээр сурч байгаа оюутнуудын сургалтын төлбөрийг шийдээгүй гэж хариулт өгсөн. Энд хариулж байгаа албан тушаалтан шийдэж байгаа гэж хариулт өгсөн. Зөрүүтэй мэдээлэл байгаад байгаа. Тэгэхээр энийг бид нар бүүр тодорхой заалтуудаа оруулчихъя. Ер нь асуудалд Байнгын хорооноос засгийн тодорхой байх тусмаа илүү үр дүн өгнө гэж харж байна.

Тийм учраас зарчмын зөрүүтэй заалт 7 дээр Шинжлэх ухаан, технологийн их сургуульд газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэлийн ангид суралцах оюутнуудын сургалтын төлбөрийн шуурхай асуудлыг цаг тухайд нь шуурхай шийдвэрлэх, арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам Ашигт малтмал, газрын тосны газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд үүрэг болгох гэсэн ийм заалт нэмээд өгчихье. Ингээд ер нь бүгдийг нь цэгцтэй яг тов тодорхой өгөхгүй бол бөөрөнхий заалт байх тусмаа эргээд бид нар бөөрөнхий л тайлбар авна. Тэгээд үйл

ажиллагаа маань тэгээд л тийм бөөрөнхий л болоод үр дүн муу гарна шүү гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх. Баярлалаа.

Т.Энхтүвшин: Батлут гишүүний зарчмын зөрөгчтэй саналыг авчихъя. Уншаад санал хураачихъя. Зарчмын зөрүүтэй 2 санал гарсан. Санал хураана. Улсын Их Хурлын гишүүн Аубакир гишүүний зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад ашиглагдаж байгаа машин механизм, тоног төхөөрөмжийг бүтээн байгуулалтын хугацаанд байршуулах боломжийг бүрдүүлэх гэсэн ийм санал өгсөн. Машин механизм гэж байна. Тоног төхөөрөмж. За тэгвэл машин, тоног төхөөрөмж гэж унших нь байна шүү тийм ээ. Санал хураая.

77.8 хувиар дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүн Батлут гишүүнээс санал гарсан байна. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд газрын тос боловсруулах үйлдвэрлэлийн инженерчлэлийн ангид суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийн асуудлыг цаг тухайд нь шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд үүрэг болгох гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан байна. Дээрх зарчмын зөрүүтэй санал дээр санал хураая.

3 дахь заалтыг бол Ганбаатар гишүүн. 77.8 хувьтай дэмжлээ.

Ганбаатар гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг, Батлут гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя. 3 дахь заалт юм байна тээ? Засгийн газраас Петро, Дайчин Тамсаг компани болон Хятадын газрын тосны үндэсний компаниудтай хэлцэл хийж,

бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу ирээдүйд олборлох газрын тосыг Монголын газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх олборлолтын хэмжээг олборлолтын хэмжээг олборлолтын хэмжээг энэ юу гэж байна? Ашиглалтын төлөвлөгөөнд заасан 1.5 сая тоннд жилд хүрэх асуудлыг албажуулах гэж нэмэх гэж нэмэх гэсэн байж байна. 3 дугаар заалт дээр нэмж байгаа шүү. Энэ заалтын дагуу санал хураая.

Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай. 77.8 хувиар дэмжлээ гишүүдийн, батлагдлаа.

Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг бүхэлд нь баталъя гэдгээр санал хураая. Санал хураалт.

55.6 хувиар гишүүд дэмжлээ. Наранбаатар гишүүн санал хэлэх юм уу? Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Би сая дэмжиж санал өгсөн боловч эсрэг гарчихлаар төхөөрөмж ажилласангүй. Дэмжсэнээр протоколд тусгаж өгөөч.

Т.Энхтүвшин: Наранбаатар гишүүний саналыг протоколд тэмдэглээрэй. Аубакир гишүүн бас дэмжсэн байна. Протоколд оруулаарай.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдэж байна. Оролцсон ажлын хэсгийн гишүүддээ бас баярлалаа. Улсын Их Хурлын гишүүддээ бас баярлалаа.

12.08 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР